

# Сайнмэдээний Номууд

Хичээл 4

Лукийн Сайнмэдээ

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

### **ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ**

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг.

#### **Библийн боловсрол. Бүх дэлхийд. Үнэгүйгээр**

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <[www.thirdmill.org](http://www.thirdmill.org)> цахим хуудсаар зочлоорой.

# Сайнмэдээний Номууд

Дөрөвдүгээр хичээл

Лукийн Сайнмэдээ

## Агуулга

|                                                      |    |
|------------------------------------------------------|----|
| УДИРТГАЛ .....                                       | 1  |
| ТҮҮХЭН НӨХЦӨЛ .....                                  | 1  |
| Бичээч .....                                         | 1  |
| Уламжлалт Үзэл .....                                 | 2  |
| Хувийн Амьдралын Түүх .....                          | 5  |
| Анхны Хүлээн авагчид .....                           | 7  |
| Теофил .....                                         | 8  |
| Өргөн хүрээний Хүлээн авагчид .....                  | 9  |
| Үндсэн шалтгаан .....                                | 10 |
| Огноо .....                                          | 10 |
| Зорилго .....                                        | 11 |
| БҮТЭЦ БА АГУУЛГА .....                               | 12 |
| Есүсийн Амьдралын Эхлэл .....                        | 13 |
| Төрөлтийг Тунхагласан нь .....                       | 14 |
| Төрөл ба Хүүхэд нас .....                            | 14 |
| Есүсийн Талаарх Иоханы Тунхаглал .....               | 17 |
| Бурханы Хүү Гэдгийг Баталсан нь .....                | 18 |
| Есүсийн Галил дахь Үйлчлэл .....                     | 21 |
| Назар дахь Номлол .....                              | 21 |
| Сургаал ба Гайхамшгууд .....                         | 22 |
| Баптисч Иохан .....                                  | 24 |
| Сургаал ба Гайхамшгууд .....                         | 25 |
| Арван Хоёр Элчээ Бэлтгэсэн нь .....                  | 25 |
| Есүсийн Йерусалим руу хийсэн Аялал .....             | 25 |
| Дагалдагчийн Мөн чанар .....                         | 26 |
| Эрчимжиж Буй Эсэргүүцэл .....                        | 29 |
| Дагалдагч Байх Өртөг .....                           | 30 |
| Есүсийн Зориулалт .....                              | 30 |
| Есүсийн Йерусалим ба Эргэн Тойрон дахь Үйлчлэл ..... | 31 |
| Есүсийн Цовдлол ба Амилал .....                      | 33 |
| Баривчилгаа, Шүүлт ба Үхэл .....                     | 34 |
| Амилал ба Тэнгэрт Одсон нь .....                     | 36 |

|                            |           |
|----------------------------|-----------|
| <b>ГОЛ СЭДВҮҮД .....</b>   | <b>37</b> |
| Авралын Тодорхойлолт.....  | 38        |
| Бурхан бол Аврагч.....     | 41        |
| Бурханы Хүч.....           | 41        |
| Бурханы Төлөвлөгөө.....    | 42        |
| Бурханы Хүү.....           | 43        |
| Аврагдсан Хүмүүс .....     | 43        |
| <b>ДҮГНЭЛТ.....</b>        | <b>48</b> |
| <b>ХАМТРАГЧИД.....</b>     | <b>49</b> |
| <b>ҮГСИЙН ТАЙЛБАР.....</b> | <b>51</b> |

# Сайнмэдээний Номууд

Дөрөвдүгээр хичээл

Лукийн Сайнмэдээ


## УДИРТГАЛ

Хэдэн жилийн өмнө шатаж буй албан газрын барилгад хэсэг хүмүүс гарч чадахгүй боогдсон тухай мэдээ гарсан. Тэгтэл нэг залуу өрөөнд гэнэт гарч ирэн тэд дууг нь сонсон дагасаар аюулгүй газарт очжээ. Барилгын энд тэндээс гарч ирсэн олон амьд үлдэгсдийн түүхээс харахад тэрээр энэ байшинд ажиллаж таарсан сайн дурын гал сөнөөгч байв. Хэдий тэрээр уг галд амиа алдсан боловч олон хүнийг үхлээс аварчээ.

Бусад Сайнмэдээний бичээчдээс илүүгээр Лук Есүсийг аврагч хэмээн дүрсэлсэн байдаг. Бид өөрсдөө ухаарч байгаа эсэхээс үл хамааран хүн төрөлхтөн ямар ч тусламж, найдваргүйгээр төөрсөн, цөхрөнгөө барсан байдалтай байна. Бидний өмнө буй Бурханы шүүлтээс зугтах арга гэж үгүй. Харин Лукийн Сайнмэдээнд Есүс Өөрийн амиа золиослон төлж, биднийг аврахаар ирсэн гэдгийг сануулдаг.

Энэ бол бидний "Сайнмэдээнүүд" цувралын дөрөв дэх хичээл бөгөөд бид үүнийг "Лукийн Сайнмэдээ" гэж нэрлэсэн. Энэ хичээлээрээ бид Шинэ Гэрээний гурав дахь сайнмэдээг илүү ойлгож уншин, Түүний сургаалыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар судлах болно.

Бид Лукийн Сайнмэдээг гурван үе шаттайгаар харах болно. Нэгдүгээрт, бид уг номын түүхэн нөхцөлийг авч үзэх болно. Хоёрдугаарт, бид бүтэц ба агуулгыг нь судлах болно. Гуравдугаарт, бид түүний гол сэдвүүдийг авч үзэх юм. Ингээд Лукийн Сайнмэдээний түүхэн нөхцөлөөс эхэлцгээе.



## ТҮҮХЭН НӨХЦӨЛ

Бид Лукийн Сайнмэдээний түүхэн нөхцөлийг судлахын тулд бичээч, анхны хүлээн авагчид болон бичих болсон үндсэн шалтгаан буюу нөхцөл байдлын талаар авч үзэх болно. Эхлээд уг номын бичээчийн талаар харцгаая.

### Бичээч

Лукийн Сайнмэдээ нь “хоёр цуврал номын эхнийх нь гэдгээрээ нэлээн

танигдсан болохыг юуны өмнө дурдах нь зүйтэй. Хоёр дахь нь Үйлс ном юм. Үүний улмаас Лук номын бичээчийн талаарх асуудал нь Үйлс номынхтой нягт холбоотой байдаг. Лук 1:1-4 дээрх оршил хэсгийг сонсоцгооё. Энд:

“Бидний дунд биелсэн үйл явдлуудын тухай хүүрнэлийг олон хүн эмхэтгэхийг хичээсэн билээ. Анхнаас нь нүдээр үзсэн гэрчлэгчид хийгээд үгийн үйлчлэгч бологсдоос бидэнд уламжилсны адил би ч бас энэ бүгдийг эхнээс нь нягтлан судалсан тул танд дэс дараалан бичиж өгөх нь зүйтэй юм, эрхэм хүндэт Теофил минь! Таны заалгасан зүйлс нь бат үнэн гэдгийг үүгээр та мэдэх болно” (Лук 1:1-4).

Үүнийг Үйлс 1:1-2 дээрх ижил төстэй оршилтой харьцуулан харья. Энд:

“Теофил оо, би эхнийхээ номд, Есүсийн юу үйлдэж, сургаж эхэлснээс авхуулан, дээш өргөгдөн одсон өдөр хүртэлх бүгдийг бичсэн билээ” гэжээ (Үйлс 1:1-2).

Энэ хоёр оршилд бичээч нь Теофил гэдэг хүнд захидал бичсэнийг харуулж байна. Мөн Үйлс номын оршил нь өмнө бичигдсэн нэгэн номын тухай өгүүлдэг. Энэ нь ихэнх судлаачдыг өмнөх ном нь Лукийн Сайнмэдээ байсан гэж дүгнэхэд хүргэсэн.

Энэ хоёр номыг нэг хүн бичсэн гэх өөр баримт бий. Лукийн Грек хэлний хэв маяг нь Үйлс дэх Грек хэлтэй төстэй боловч бусад Сайнмэдээний хэв маягаас эрс ялгаатай. Номууд нь нийтлэг сэдвүүд болох Сайнмэдээний бүх хүнд хандсан уриалга, Ариун Сүнсний ажил, Бурханы хүсэл ба үгийн татгалзах аргагүй хүч, мөн Христийн "аврал"-ын ажил зэргийг онцолдог. Тэгэхээр нэг бичээч энэ хоёр номыг бичсэн гэж үзвэл тэр нь хэн байх вэ?

Бид энэхүү гурав дахь Сайнмэдээний бичээчийн талаар хоёр үе шаттайгаар судална. Эхлээд үүнийг Лук бичсэн гэсэн уламжлалт үзлийг бид авч үзнэ. Хоёрдугаарт, бид Лукийн өөрийнх нь түүхийг судална. Эхлээд Лук энэ Сайнмэдээг бичсэн гэсэн уламжлалт үзлийг харцгаая.

## Уламжлалт Үзэл

Лукийн Сайнмэдээ нь бичээчийнхээ нэрийг дурдаагүй тул нэг ёсондоо нэр нь тодорхойгүй ном гэсэн үг. Гэхдээ энэ нь гайхаад байх зүйл биш юм. Угтаа Теофил нь энэ номыг хэн бичсэнийг таньдаг байсан тул бичээч өөрийгөө хэлэх шаардлагагүй байв. Тийм боловч бичээчийн хэн болох талаар хэд хэдэн мэдээлэл бүхий эх сурвалж бий.

Лук гурав дахь Сайнмэдээний номыг бичсэн гэх уламжлалт үзлийг баталдаг дор хаяж гурван төрлийн нотолгоо байна. Нэгдүгээрт, Шинэ Гэрээний бусад хэсгүүдийн тайлбарууд нь түүнийг бичээч болохыг нь харуулдаг.

Уг номын бичээч нь үйлчлэлийнхээ сүүлийн жилүүдэд Паултай хамт байсан гэдгийг Шинэ Гэрээ өгүүлдэг. Жишээлбэл, Үйлс номд бичээч заримдаа "тэд" гэсэн

гуравдугаар биеийн олон тоогоор, заримдаа "бид" гэсэн нэгдүгээр биеийн олон тоогоор үйл явдлыг өгүүлсэн байдаг. Эдгээр нэгдүгээр биеийн олон тооны өгүүлэмжийн сүүлчийнх нь Паулын Ром руу хийсэн аяллыг дүрслэх ба энэ тухай Үйлс 27:1–28:16 дээр гардаг.

Үүнээс гадна Паулын захидлуудад Лукыг энэ хугацаанд түүнтэй хамт ажиллаж байсан цөөхөн хүний нэг байсан гэж тодорхойлдог. Жишээлбэл, 2Тимот 4:11 дээр буюу өөрийнх нь үхэл ойртож байх үед Паул Тимотод "Ганц Лук надтай хамт байна" гэж хэлсэн. Энэ мэт мэдээлэл нь Лук энэхүү гурав дахь Сайнмэдээг болон Үйлс номыг бичсэн гэдгийг шууд нотлохгүй ч байх магадлал тун өндөр байдаг.

Хоёрдугаарт, Лукийн Сайнмэдээний эхэн үеийн гар бичвэрүүд мөн Лукыг бичээч нь гэдгийг заасан байдаг.

Эртний гар бичвэрүүдийн огноог тогтоох нь үнэхээр шинжлэх ухааны нарийн техник шаарддаг. Эрдэмтэд энэ эдгээр эртний гар бичвэрүүдийг он цагийг тогтооход ашигладаг гурван чухал баримт байдаг. Нэгдүгээрт, үнэндээ хамгийн чухал нь л даа. Заримдаа энэ нь оюутнуудыг гайхшируулдаг. Энэ бол палеограф буюу эртний бичвэр судлал юм. Палеограф гэдэг нь эртний гар бичвэр гэсэн утгатай. "Палео" нь хуучин, "граф" нь бичвэр гэсэн үг байдаг. Тиймээс эртний бичвэр гэдэг үг болж байгаа юм. Судлаачид болон палеографийн мэргэжилтнүүд тодорхой хэл дээрх гар бичвэр нь цаг хугацааны явцад өөрчлөгдөх хандлагатай байдаг тул хэзээ бичигдсэнийг нь заримдаа хэдэн арван жилийн дотор, бүр тодруулбал тавин жил дотор тодорхой хэлж чаддаг. Заримдаа цагаан толгойн үсэг нь мэдээжийн хэрэг бичвэр гэдэг утгаараа өөрчлөгддөг. Тэр дундаа бичих арга барилын хувьд өөрчлөгдөх нь тодорхой байдаг. Тиймээс л палеограф буюу бичвэр судлалыг хийдэг юм. Хоёрдугаарт, нэг төрлийн химийн шинжилгээг хийдэг. Жишээлбэл, нүүрстөрөгчийн арван дөрөв буюу задралд орох хугацааг тодорхойлдог. Эсвэл насжилтыг нь тодорхойлохын тулд бэхийг нь, амьтны арьс эсвэл тухайн бичвэрийн бичигдсэн аливаа зүйлсийг бүгдийг нь туршиж үздэг туршилтуудыг хийдэг. Гар бичвэрийн огноог тодорхойлох гурав дахь арга бол энэ талаарх хөндлөнгийн ямар нэг бодит тайлбар эсвэл мэдэгдлүүд юм. Эдгээрийг хуулсан бичээчид нь ховор тохиолдолд огноог нь тодорхойлсон байх юм уу заримдаа тэд тухайн баримт бичгийг хэзээ хуулж авснаа тусгайлан таниулах зорилгоор ямар нэгэн тэмдэглэгээ эсвэл тайлбар хийдэг. Тэгэхээр дээрх бүгд нь гар бичвэрийн огноог тогтоох гурван өөр арга юм.

— Др. Марк Л. Страусс

Лукийн Сайнмэдээний хамгийн найдвартай эртний гар бичвэрүүдийн нэг бол

"Пи-75" гэж нэрлэгддэг 75 дугаар папирус буюу хуйлмал ном юм. Энэхүү гар бичвэр нь МЭ 180 оны үед бичигдсэн нь тогтоогдсон. Энэ нь гурав дахь Сайнмэдээний талаар бусад эртний гар бичвэрүүдээс хамаагүй ихийг агуулдаг бөгөөд "Лукийнх" гэсэн гарчигтай байдаг.

Бусад олон эртний гар бичвэрүүд ч мөн Лукыг уг Сайнмэдээний бичээч гэж тодорхойлсон байдаг ба эдгээр нь үүнийг өөр хэн нэгэнтэй холбоогүй байдаг. Гуравдугаарт, эртний чуулганы бичвэрүүд ч мөн Лукыг бичээч нь мөн хэмээн тодорхойлсон байдаг.

Анхны чуулганы чухал баримт бичгүүд ч Лукийг бичээч нь гэж үздэг. МЭ 170-180 оны үед хамаарах Мураторийн бичвэр нь анхны чуулганы хувьд каноны гэж үзсэн Шинэ Гэрээний номуудыг жагсаасан хамгийн эртний баримт бичиг юм. Энэ нь Лукийг гурав дахь Сайнмэдээний бичээч мөн гэдгийг тодорхой баталдаг.

Эртний өөр нэгэн гэрч бол тэрс үзэлтэн Марсионыг няцаахын тулд МЭ 160-180 оны үед бичигдсэн Лукийн Сайнмэдээний талаарх Марсионы Эсрэг Оршил Үгс юм. Энэ нь уг Сайнмэдээний талаар ийнхүү өгүүлсэн байдаг. Энд:

**Сирийн Антиох хүн, эмч мэргэжилтэй Лук элч нарын дагалдагч байсан. Хожим нь тэр Паулыг дагалдан явсан... Лук Сүнсний онгодоор бүхэл бүтэн Сайнмэдээгээ Ахай мужид бичсэн” гэжээ.**

Түүнээс гадна хоёр, гуравдугаар зууны олон чуулганы удирдагч нар Лукыг уг номын бичээч гэж үзсэн. Жишээлбэл, үүнд МЭ 130-202 онд амьдарч байсан Иренаус, МЭ 150-215 онд амьдарч байсан Александрийн Клемент болон МЭ 155-230 онд амьдарч байсан Тертуллиан нар орно.



Иренаус

Александрийн  
Клемент

Тертуллиан

Лук бол гурав дахь Сайнмэдээний бичээч гэдэгт бид бүрэн итгэлтэй байж болно гэж би боддог. Бага Азийн хойгийн дээхнүүр гаталж Трой гэх газарт ирсэн Паултай уулзсан хүн нь Лук эмч байсныг бид Үйлс номоос хардаг. Тэрээр Луктай уулзсан бөгөөд тэд Филиппой руу хамтдаа аялж, тэндээ эмчээр үлдсэн байдаг. Дараа нь МЭ 57 онд Филиппойгоос Йерусалим руу явахдаа тэрээр



Паултай дахин нэгджээ. Тиймээс Шинэ Гэрээний бидэнд өгч буй зураглал нь Лук Паулыг сайн мэддэг төдийгүй түүнтэй хамт аялан явсан хүн гэдгийг харуулдаг. Тиймээс энд өгүүлж буй Лук бол Лукийн Сайнмэдээг бичсэн нэгэн гэдгийг батлах бүхий л нотолгоо бий.

— Др. Петр Уолкер

Хэрэв та Паулын хамтрагч хэн бэ гэдгийг таах гээд үзвэл Лук гэж хариулахгүй л байх. Тэрээр Паулын захидлуудад тэр бүр дурдагдаад байдаггүй. Та Тит юм уу эсвэл өөр хэн нэгний нэрийг хэлж магадгүй юм. Тиймээс Паулын захидлуудад тэрээр тийм ч их дурдагдаагүй байдаг нь Лукийн Сайнмэдээ болоод Үйлс номыг Лук бичсэн гэдэг нь зөв байх магадлалтайг харуулдаг. Гэхдээ Сайнмэдээнүүдийг анх дамжуулан уншиж байсан эртний үе руу буцаж, үүнд ойрхон байсан хүмүүсийн нэрст Сайнмэдээнүүдийг хамааруулан бодох нь сайн үндэслэл болно гэж би бодож байна. Тиймээс Үйлс номын бичээч нь Паулын хамтрагч бөгөөд энэ нь Лук юм хэмээн үзвэл Үйлс ба Лук номын бичээч нь Паулыг зарим аялалд нь дагалдан явсан хамтран зүтгэгчдийнх нэг болох Лук байх магадлалтай гэж би бодож байна.

— Др. Ричард Баукхэм

Лук энэхүү Сайнмэдээг бичсэн гэсэн уламжлалт үзлийг батлан харсан тул одоо түүний хувийн амьдралын түүхийг хамтдаа харцгаая.

## Хувийн Амьдралын Түүх

Шинэ Гэрээнд Лукийн хувийн түүхийн талаар дор хаяж дөрвөн зүйлсийг өгүүлдэг. Нэгдүгээрт, тэрээр элч биш байсан. Чухамдаа Лук өгүүлсэн үйл явдлуудынхаа алийг нь ч нүдээр үзээгүй гэж харагддаг.

Лук 1:1-2-р эшлэлд энэ тухай дэлгэрэнгүй өгүүлдэг. Энд:

“Бидний дунд биелсэн үйл явдлуудын тухай хүүрнэлийг олон хүн эмхэтгэхийг хичээсэн билээ. Анхнаас нь нүдээр үзсэн гэрчлэгчид хийгээд үгийн үйлчлэгч бологсдоос бидэнд уламжилсны адил...” гэжээ (Лук 1:1-2).

Лукийн Сайнмэдээ бол түүхчдийн түүхээ танилцуулахдаа бичдэг байсантай тун төстэй оршилтой цорын ганц Сайнмэдээний ном юм

л даа. Тиймээс энэ нь Лук тухайн үеийн түүхэн арга барилыг ухамсартайгаар дагаж мөрдөж байсан гэдгийг харуулж байна. Мөн тэрээр эх сурвалжийнхаа талаар оршил хэсэгтээ өгүүлсэн байдаг. Тэрээр өөрийгөө нүдэн гэрч гэж хэлээгүй ч нүдээр үзсэн гэрчийн мэдүүлгийг тэмдэглэн бичиж байгаа гэдгээ тодорхой хэлсэн байдаг. Тиймээс бидэнд нүдээр үзсэн гэрч нарын гэрчлэл байгаа гэсэн үг юм. Гэвч дараа нь Паул Йерусалимд очсоны дараа буюу Йерусалим руу хийсэн түүний сүүлчийн аялалд нь Лук түүнтэй хамт байсан бөгөөд Паул 2 жил орчим шоронд хоригдсон юм. Лук тэр хугацаанд Йерусалим болон Палестины бусад газруудаар хэрэн явж байсан харагддаг. Тиймээс тэрхүү 2 жилийн хугацаанд түүнд эртний сайн түүхчдийн хийдэгчлэн нүдэн гэрчүүд болох Йерусалимын чуулганы гишүүдтэй ярилцах боломж олонтоо тохиосон нь тодорхой. Тухайлбал, тэр үед байсан Эзэний дүү болох Иаков гэх мэт. Мөн арван хоёр элчийн зарим нь Йерусалимд эсвэл Палестины бусад газруудаар байсан байх. Тиймээс Лук нүдэн гэрчүүдтэй ярилцах нөхцөл боломж бэлхнээ бүрддэг байсан байх нь шүү дээ. Тэгээд мэдээж тэрээр Паултай Ром руу явсан бөгөөд тэнд магадгүй Есүсийн талаар үзэж сонссоноо ярих бусад хүмүүс ч амьдарч байсан байх. Тиймээс Лукыг нүдэн гэрчүүдтэй шууд уулзах боломжтой нөхцөл байдалд байсан гэж хэлхээр байна.

— Др. Ричард Баукхэм

Хоёрдугаарт, Лук мөн Христигтэлт харь үндэстэн байсан бололтой харагддаг. Паул шоронгоос Колоссайчуудад захидал бичихдээ тухайн үед өөртэй нь хамт байсан Лукаас хэмээн мэндчилгээ илгээжээ. Колоссай номын 4:14 дээр Паул юу гэж бичсэнийг сонсоцгооё. Тэрээр энд:

“Хайрт эмч Лук та нарт мэнд хүргэж байна. Дем ч бас” гэжээ (Колоссай 4:14).

10-11-р эшлэлүүдэд Паул Аристарх, Марк, Иуст нар л тэр үед түүнтэй хамт ажиллаж байсан иудейчүүд байлаа гэж хэлсэн нь маш их ач холбогдолтой байна. Тэгэхлээр Лукыг харь үндэстэн байсан гэж дүгнэх нь үндэслэлтэй юм. Үйлс 1:19 дээр Лук арамей хэлийг “тэд өөрсдийнхөө хэлээр” гэж тодорхойлсон нь үүнийг баталж байна. Арамей хэл нь Иудейчүүдийн хэл байсан ч түүнийх биш байв.

Гуравдугаарт, Лук бас сайн боловсролтой байсан бололтой. Шинэ Гэрээний олон номыг Грек хэлний нэлээд түгээмэл хэв маягаар бичсэн байдаг. Харин Лукийн Сайнмэдээ нь энэ хэлийг нэлээд уран чадварлаг байдлаар хэрэглэсэн нь харагддаг.

Лук сайн боловсролтой байсныг Колоссай 4:14 дээр Паул түүнийг “эмч” хэмээн тодотгосноос нь харж болдог. Анагаах ухаан нь Шинэ Гэрээний өдрүүдэд өнөөгийнх шиг албан ёсны мэргэжлийн чиглэл биш байсан боловч ур чадвар, авьяас

бэлэг, суралцах чадвартай хүнийг шаарддаг байлаа.

Лукийн хувийн түүхийн талаар бидний мэдэж болох дөрөв дэх зүйл нь тэрээр Үйлс номд дурдсан олон үйл явдалд Паулын хамтран үйлчлэгч байсан явдал юм.

Филемон 24 дээр Паул түүнийг өөрийн "хамтран зүтгэгч" гэжээ. Үйлс 16:6-10-т бичсэнээр Лук эхлээд Паултай Тройд нийлж, Македон руу явах илгээлтийн дуудлагад нь нэгдэн, түүнтэй хамт явсан. Үйлс 16:40–20:5-д бичигдсэнээр Филиппойд удаан хугацаагаар байхаас бусад үед Лук Паултай байнга хамт байжээ. Лукийн итгэмжтэй байдал нь Үйлс 27:1 дээр буюу ялангуяа Паулын Ром руу хийх аюулт аянд нэгдсэн байдгаас харагддаг.

**Шинэ Гэрээний бүх хүмүүсийн тухай бодох юм бол би Луктай уулзахыг хүсдэг юм. Нэгэн цагт би эмч болно гэж боддог байсан болохоор ч тэр үү тэрээр сонирхлыг маань үргэлж л татсаар ирсэн. Сайнмэдээний номыг бичсэн гэх шаардлагыг тэрээр хангасан эсэх тухайд миний бодлоор хэд хэдэн зүйлс таарч байгаа санагддаг. Эхнийх нь зүгээр л эзэн биеэ хэрхэн илэрхийлсэнтэй нь холбоотой. Үйлс 16-р бүлэгт Лук "бид" хэмээн ярьж эхэлсэн байдаг. Гэнэт тэрээр үйл явдал дотор байгаагаар буюу дам сонссоноо мэдээлээгүй байдаг. Харин Лук болж буй үйл явдлын нэг хэсэг байсан хүмүүстэй нэгдэж, анхны Христитгэлийн туршлагаас амсах боломжтой байсан гэсэн үг юм. Энэ бол үнэхээр сэтгэл хөдөлгөм явдал. Хоёр дахь зүйл нь тэрээр эмч байсан явдал юм. Би өөрөө эмч болох гэж бэлдэж байсан хүний хувьд оношийг зөв тогтоохыг хүсдэг хүн ямар байдгийг мэднэ. Тэд үнэн зөв мэдээллийг олж авахын тулд тун болгоомжтой байх бөгөөд нарийн мэдээллүүд нь алдаа мадаггүй байгаасай хэмээн хүсдэг. Учир нь тэдний дүгнэлт нь өвчтөний сайн сайхны төлөө байх ёстой шүү дээ. Лукийн тухай миний гайхширдаг гурав дахь зүйл бол Грек-Ромын ертөнцөөр аялж байхад нь түүнд байсан үзэл хараа юм. Түүний Сайнмэдээний хүүрнэлийн үзэл бодол нь Израил эсвэл Палестинаар хязгаарлагдаагүй байдаг. Энэ бол дэлхий дахиныг хамарсан даяарчилсан үзэл бодол юм. Христитгэлт Сайнмэдээ даяарчлагдаж байгаа тухайд анхаарал тавьж буй өнөө үед бид Лукыг үнэхээр сайн ойлгож унших боломжтой. Яагаад гэвэл тэрээр Грек, Ром болон Грек-Ромын ертөнцийн бусад хэсэгт нь амьдарч байсан юм. Есүсийн мэдээ нь тухайн соёлдоо хэрхэн хэрэгжиж болохыг харах боломж түүнд байлаа.**

— Др. Стив Харпер

Гурав дахь Сайнмэдээний номын бичээчийн талаар судалсны дараа бид одоо Лукийн анхны хүлээн авагчид нь хэн байсныг харах болно.

## **АНХНЫ ХҮЛЭЭН АВАГЧИД**

Лукийн анхны хүлээн авагчдыг бид хоёр арга замаар судлах болно. Эхлээд бид уг номын Теофилд зориулсан гэх шууд илэрхийллийг харах шаардлагатай. Хоёрдугаарт, энэ ном нь илүү өргөн хүрээний хүлээн авагчдад зориулагдсан байх боломжтой талаар үзнэ. Лукийн анхны уншигч болох Теофилоос эхэлцгээе.

## Теофил

Теофил гэж хэн байсан буюу Лук 1:1-4 болон мэдээж Үйлс 1:1-2 дээрх нь чухам юу гэсэн утгатай болох талаар олон зуун жилийн турш маш их маргаан өрнөж байсан. Теофил буюу "Теофилус" гэдэг үг нь "Бурханыг хайрлагч" гэсэн утгатай тул олон хүн Теофил нь бодит хувь хүн биш, харин чуулган дахь Бурханыг хайрлагчид буюу уг номын уншигчдыг төлөөлүүлж байгаа гэж үздэг. Нөгөө талаар, мэдээж өөр нэг үндсэн таамаг нь Теофилог бодит хүн байсан гэж үздэг. Ихэнх судлаачид, мөн миний хувьд ч энэ хоёр дахь үзэл нь илүү үнэ цэнтэй гэдэгт санал нийлдэг. Учир нь Лук түүнийг "эрхэм хүндэт" буюу "*кратисте*" гэж тодорхойлсон бөгөөд дараа нь Лук яг энэ үг болох "*кратисте*" хэмээн Ромын түшмэд Фелик, Агрийн хоёрыг тодорхойлсон байдаг. Тиймээс энэ нь Лукийн хувьд өндөр байр суурь эзэлдэг хүн, ялангуяа Ромын засгийн газарт өндөр байр суурь бүхий хүнтэй холбоотой албан ёсны илэрхийлэл байсан харагддаг. Үүн дээр нэмэхэд Лук 1:1-4 дээрхийг харвал хэн нэгэнд зориулсан дурсгал үгс шиг санагддаг. Өөрөөр хэлбэл энэ нь хэн нэгэнд зориулан бичсэн дурсгал үгсийн оршлын хэв маягт сайн тохирдог. Түүхэн бүтээлүүд нь ихэвчлэн тухайн бүтээлийг бүтээхэд мөнгө төлсөн ивээн тэтгэгчдээ зориулж ийм хэв маягаар дурсгал үгс бичдэг байлаа. Тиймээс энэ нь бидний энэ талаар мэддэг зүйлстэй үнэхээр нийцдэг. Тэгэхээр миний хэлснээр Теофил бол жинхэнэ хүн байсан нь бараг гарцаагүй.

— Др. Дэвид Р. Бауэр

Лукийн оршил нь Теофил бол түүний ивээн тэтгэгч, бүтээлийг нь захиалж, санхүүгийн хувьд дэмжсэн хүн байсныг харуулдаг. Лук 1:3 дээр Лук ажлаа *кратисте Теофил* буюу "эрхэм хүндэт Теофил минь" гэж хандсан. *Кратисте* гэдэг нэр томъёо нь ихээхэн хүндэтгэлийн илэрхийлж байв. Үнэн хэрэгтээ бүх Шинэ Гэрээнд үүнээс гадна зөвхөн хоёр өөр хүнийг л ийнхүү дүрсэлсэн байдаг нь Ромын захирагч Фелик, Фест нар юм. Хэрэв Теофил Ромын өндөр албан тушаалтан биш байсан гэж үзвэл тэрээр нэр хүндтэй, чухал байр суурьтай хүн байсан нь тодорхой.



Теофил бол Лукийн ивээн тэтгэгч, шавь байв.

Гэхдээ Лук, Теофил хоёрын харилцаа нь зүгээр ивээн тэтгэгч тэтгүүлэгчээс өөр олон талтай байсан харагддаг. Зарим утгаараа Теофил бас Лукийн шавь байсан. Энэ талаар бид Лук 1:3-4 дээрээс олж уншдаг. Энд:

“би ч бас энэ бүгдийг эхнээс нь нягтлан судалсан тул танд дэс дараалан бичиж өгөх нь зүйтэй юм, эрхэм хүндэт Теофил минь! Таны заалгасан зүйлс нь бат үнэн гэдгийг үүгээр та мэдэх болно” гэжээ (Лук 1:3-4).

Теофил Есүсийн тухай аль хэдийн мэддэг байжээ. Гэвч Лук Теофилд өөрт нь заасан зүйлд итгэх итгэлийг төрүүлэхийн тулд Есүсийн амьдралын тухай илүү бүрэн дүүрэн, эмх цэгцтэй түүх бичжээ. Лук Теофилийг анхны хүлээн авагч нь хэмээн тодорхой дурдсан байгаа ч тэрээр нь илүү өргөн хүрээний хүлээн авагчдад зориулж бичсэн гэж бодох нь зүйтэй.

### Өргөн Хүрээний Хүлээн Авагчид

Лук зөвхөн Теофилоос илүү өргөн хүрээний хүмүүст зориулж бичсэн гэж бодох олон шалтгаан бий. Нэгийг нь дурдвал эртний Христитгэгчид өөр хоорондоо захидлууд болоод бусад бичвэрүүдийг дамжуулан унших хандлагатай байв. Ганцхан жишээ болгож Паул Колоссай 4:16-д юу гэж бичсэнийг сонсоцгооё. Тэрээр энд:

“Энэ захиаг та нар уншаад лаодикчуудын чуулганд бас уншуулаарай.  
Та нар ч гэсэн Лаодикийнхыг уншаарай” гэжээ. (Колоссай 4:16).

Эртний Христитгэгчид бичвэрүүдээ бусадтай хуваалцан унших хандлагатай байсан.

Тиймээс Теофил Лукийн номыг хуваалцах хүсэлтэй байсан гэж үзэх нь үндэслэлтэй юм.

Үүнээс гадна Сайнмэдээний уран зохиолын хувьд өндөр чанартай бичигдсэн нь Лук ч гэсэн илүү өргөн хүрээний хүлээн авагчдыг бодож бичсэн гэдгийг бараг баттай болгодог. Хэв маяг нь зөвхөн нэг хүнд л зориулсан хувийн тэмдэглэл биш байдаг. Лук номын түүхэн судалгаа нь Лук 1:3-т мөн илүү өргөн хүрээний хүлээн авагчдад зориулсан болохыг харуулдаг. Үүнээс гадна Лук ба Үйлс ном нь урт байдаг нь тэрээр илүү олон хүлээн авагчдад зориулж ийнхүү томоохон ажил болгож бичсэн харагддаг. Гэхдээ энэ өргөн хүрээний хүлээн авагчид нь хэн байсан бэ?

Лук үндсэндээ харь үндэстний Христитгэгчдэд зориулж бичсэн байх магадлалтай. Жишээлбэл, түүний Грек хэлний хэв маяг нь харь үндэстнүүдийнхтэй адил байв. Мөн Бурханы хаанчлалын Сайнмэдээний даяар шинжтэй уриалгад түүний онцлон тэмдэглэсэн гол агуулга нь аврал бол бүх үндэстэнд зориулагдсан гэсэн утгатай. Мэдээж хэрэг, Лукийн Сайнмэдээ нь еврей Христитгэгчдийн хувьд ч үнэ цэнтэй байх боломжтой. Гэхдээ энэ нь Матайн Сайнмэдээ шиг тэдэнд шууд чиглэсэн байгаагүй юм.

Ерөнхий утгаар нь бодоод үзвэл Бурхан түүхийн туршид буй бүх ард түмэн нь Библийг бүхэлд нь уншиж, ойлгоосой хэмээн үргэлж хүсдэг. Гэхдээ Ариун Сүнс тодорхой бичээчдийг тодорхой ном бичихэд нь онгод оруулах үедээ тэдний хувь хүний зан чанар, сонирхлын дагуу ажиллаж байсныг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Энэ утгаараа Лук Сайнмэдээгээ Теофил болон нэгдүгээр зууны бусад харь үндэстэн Христитгэгчдийн хэрэгцээнд зориулан шууд ярихын тулд зохиомжилжээ. Харин орчин үеийн хүлээн авагчид Лукийн тэдэнд бичсэн зүйлийг дам сонсдог. Хэрэв бид түүний Сайнмэдээг уншиж байхдаа Лук болон анхны хүлээн авагчдыг санаж байвал түүний бичсэн зүйлийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэхэд илүү бэлтгэлтэй байж чадна.

Сайнмэдээний бичээч болон хүлээн авагчид нь хэн болохыг мэдсэн учраас бид одоо үүний бичих болсон үндсэн шалтгааныг судлахад бэлэн болжээ.

## ҮНДСЭН ШАЛТГААН

Бид Лукийн Сайнмэдээний бичих болсон үндсэн шалтгааныг хоёр арга замаар судлах болно. Нэгдүгээрт, бид түүний бичигдсэн огноог авч үзэх болно. Хоёрдугаарт, бид Лукийн бичих болсон зорилгыг судлан харна. Ингээд уг ном хэзээ бичигдсэн талаар эхлээд харцгаая.


## Огноо

МЭ 65- 67 оны хооронд бичигдсэн гэдгийг харуулах дор хаяж хоёр хүчин зүйлс байна. Нэгдүгээрт, Шинэ Гэрээний ихэнх судлаачид Лук болон Маркийн Сайнмэдээг харьцуулснаар Лук нь Маркийн Сайнмэдээг судалгааныхаа эх сурвалжийн нэг болгон ашигласан гэдэгтэй санал нийлдэг. Маркийн тухай өмнөх хичээл дээрээ бид Марк бичигдсэн хамгийн эртний огноо нь МЭ 64 он гэж дүгнэсэн.



Хэрэв Лук Маркийг эх сурвалж болгон ашигласан гэвэл энэ нь хамгийн эртдээ магадгүй МЭ 65 оны орчимд бичигдсэн байх боломжтой.

Хоёрдугаарт, Үйлс ном нь МЭ 69 оноос хойш, магадгүй МЭ 67 оноос хойш бичигдсэн байх боломжгүй харагддаг. Үйлс нь МЭ 65 оны орчимд болсон Паулын үхлийн талаар, МЭ 68 онд дууссан Нерогийн хавчлага, эсвэл МЭ 70 онд болсон Йерусалимын сүйрэл зэрэг түүхэн чухал үйл явдлуудын талаар өгүүлээгүй байдаг. Эдгээр чухал үйл явдлуудын талаар бичээгүй байгаа нь Лук эдгээр үйл явдлууд



Лук МЭ 67 он гэхэд Сайнмэдээгээ дуусгасан байх магадлал өндөр

болохоос өмнө, эсвэл дор хаяж тэдгээрийн талаар мэдэхээсээ өмнө Үйлс номыг бичсэнийг харуулж байна. Үйлс 1:1 дээрээс харвал Лукийн Сайнмэдээ нь Үйлс номыг бичихээс өмнө дууссан байдаг. Тиймээс Лук МЭ 67 он гэхэд Сайнмэдээгээ дуусгасан байх магадлал өндөр юм. Тэр бараг л МЭ 69 онд буюу Йерусалимыг нуран унахаас өмнөхөн дуусгасан байх магадлалтай.

Лук номын бичигдсэн огноог авч үзсэн тул одоо түүний зорилгыг харцгаая.


## Зорилго

Лук 1:3-4 дээр энэ Сайнмэдээг судалж, бичих болсон дараах шалтгаануудыг тэрээр дурдсан байдаг. Энд:

“би ч бас энэ бүгдийг эхнээс нь нягтлан судалсан тул танд дэс дараалан бичиж өгөх нь зүйтэй юм, эрхэм хүндэт Теофил минь! Таны заалгасан зүйлс нь бат үнэн гэдгийг үүгээр та мэдэх болно” гэжээ (Лук 1:3-4).

Лук Иудейн Мессиа болох Есүст итгэх балчир итгэлийг нь бэхжүүлэхийн тулд

Теофил болон түүнтэй адил харь үндэстний Христитгэгчдэд зориулан бичжээ.



Нерогийн Христэд итгэгчдийг хавчсан нь өргөн хүрээний айдас

ялгаварлах үзэл хийгээд хуваагдал нь Есүс хүн төрөлхтний гэр бүл бүрд авралыг өгөхөөр ирсэн гэсэн тунхагт эргэлзэхэд хүргэж байжээ.

Эдгээр сорилт, эргэлзээний хариу болгон Лук харь үндэстний итгэгчид Есүсийг дагаснаараа зөв сонголт хийсэн гэдгийг нь урамшуулахаар бичжээ. Есүс үнэхээр Бурханы хаанчлалыг эхлүүлчихсэн. Харь үндэстний Христитгэгчид үнэхээр Бурханы гэр бүлийн гишүүд байсан. Хэрэв тэд Есүст үнэнч хэвээр үлдсэн бол авралын бүх ерөөлүүдийг хүлээн авна гэдэгт итгэлтэй байх юм.

Одоо бид Лукийн Сайнмэдээний бичигдэх болсон үндсэн шалтгааныг судалсан учраас дараагийн хоёр дахь гол сэдэв болох бүтэц, агуулга руу орцгооё.

## БҮТЭЦ БА АГУУЛГА

Дөрвөн Сайнмэдээний номууд бүгд маш өргөн утгаараа Есүсийн амьдралыг цаг хугацааны дарааллын дагуу авч үздэг болохыг бид энэ цувралын өмнөх хичээлүүдэд үзсэнийг та санаж байгаа байх. Харин явцуу утгаар тэд заримдаа өөр зарчмын дагуу Есүсийн тухай түүхүүдээ зохион байгуулсан байдаг. Жишээ нь, Матай, Марк хоёр заримдаа тодорхой сэдвийн хүрээнд материалаа цэгцэлж байсныг бид харсан. Үүнтэй харьцуулахад Лук Сайнмэдээнийхээ ихэнх хэсгийг газарзүйн байрлалын дагуу зохион байгуулсан.

Энэ хичээлийнхээ зорилгын хүрээнд бид Лукийн Сайнмэдээг 1:1-4 дээрх богино оршил болон үүний дараах таван гол бүлэг түүхүүд гэсэн дараах зургаан хэсэгт хуваан үзэх болно:

- Сайнмэдээний эхний гол хэсэг нь Есүсийн үйлчлэлийн эхлэлийг дүрсэлсэн бөгөөд Иудей болон Иордан голын нутгаар төвлөрдөг. Энэ хэсэг 1:5–4:13 хүртэл үргэлжилнэ.



- Хоёр дахь гол хэсэг нь 4:14–9:50 хүртэл үргэлжлэх Есүсийн Галил дахь үйлчлэлийн талаарх хүүрнэл юм.
- Гурав дахь гол хэсэг нь 9:51–19:27 хүртэл үргэлжлэх бөгөөд Есүсийн Йерусалим руу хийсэн аяллын талаар өгүүлдэг.
- Дөрөв дэх гол хэсэг нь 19:28–21:38 хүртэл үргэлжлэх ба Есүсийн Йерусалимд болон эргэн тойронд нь үйлчилсэн үйлчлэлийн тухай хүүрнэл юм.
- Эцэст нь, Лукийн Сайнмэдээний тав дахь буюу сүүлчийн гол хэсэг нь 22:1–24:53 хүртэл байдаг бөгөөд Есүсийн Йерусалимын гадна цовдлогдон нас барж, амилсан талаарх хүүрнэл юм.

Бид Лукийн оршил хэсгийн талаар аль хэдийн үзсэн тул Лук 1:5–4:13 дээрх Есүсийн амьдралын эхэн үеэс авхуулаад Түүний талаарх хүүрнэлийн таван гол хэсэгт анхаарлаа хандуулах болно.

### ЕСҮСИЙН АМЬДРАЛЫН ЭХЭН ҮЕ



Есүсийн амьдралын эхэн үеийн талаар өгүүлэх Лукийн энэхүү тэмдэглэл нь Есүсийг төрөхөөс яг өмнөхөн эхэлж, Түүний олон нийтэд үйлчлэхээс өмнөх бүхий л амьдралыг нь хамардаг. Эдгээр бүлгүүдэд Лукийн анхаарсан гол зүйл нь Есүс бол Бурханы Хүү хийгээд Давидын хүү хэмээснээрээ Түүнийг бүрэн дүүрэн Бурхан, бүрэн дүүрэн хүн гэдгийг харуулсан. Түүнээс гадна Давидын хүүгийн хувьд Есүс бол Бурханы хаанчлалыг дэлхийд авчрах замаар дэлхийд аврал өгөх Нэгэн буюу Мессиа болох Христ байв.

Хүүрнэлийн туршид Лук Бурхан эдгээр амлалтыг Есүсээр дамжуулан биелүүлж байгааг харуулахын тулд Хуучин Гэрээнд буй Бурханы амлалтуудыг байнга дурдаж байсан. Тиймээс Бурханд үнэнч байж, Түүний хаанчлалын ерөөлүүдийг өвлөн авах цорын ганц зам бол Есүсийг Хаан, Аврагчаар хүлээн авах явдал гэжээ.

Эдгээр бүлгийг дөрвөн үндсэн хэсэгт хувааж болно. Үүнд: Баптисч Иохан

болон Есүс төрөх талаарх тунхгууд мөн тэдний төрөлт ба хүүхэд нас, Есүсийг хэн болох талаарх Иоханы тунхаглал, мөн Есүс бол Бурханы Хүү гэдгийг баталсан гурван баталгаа зэрэг нь орно. Ингээд Лук 1:5-56 дээрх төрөх талаарх тунхгуудаас эхэлцгээе.

### **Төрөлтийг Тунхагласан нь**

Лук тэнгэр элч Габриелийн үзэгдсэнээр Сайнмэдээгээ эхлүүлсэн нь тун чухал ач холбогдолтой. Хэдэн зуун жилийн өмнө Даниел 9-р бүлэгт Габриел Израилын цөллөг хэдэн зуун жил үргэлжилнэ хэмээн зарласан байдаг. Тэд Бурханы шүүлт дор байсан хэвээр буй цагт Израил боолчлолд байх болно гэжээ. Харин Лукийн Сайнмэдээнд Габриел шүүлтийн хугацаа дуусах гэж байгааг зарлажээ.

Лук 1:5-25 дээр Габриел Баптисч Иохан мэндлэх талаар зөгнөсөн. Габриел Иудейд буй тахилч Зехариа дээр айлчилж, түүний хүүсэр эхнэр Элизабет ер бусын байдлаар хүүтэй болно хэмээжээ. Тэд хүүг Иохан гэж нэрлэх ёстой байв. Тэрээр төрсөн цагаасаа эхлэн Ариун Сүнсээр дүүрч, агуу эш үзүүлэгч Елиагийн сүнсээр үйлчилж, Бурханы авралын замыг бэлтгэх аж. Эхлээд Зехариа Габриелийн мэдээнд эргэлзсэн тул хүүгээ төрөх хүртэл хэлгүй болсон байдаг.

Лук бээр Иохан болон Есүсийн мэндлэх талаарх Габриелийн илүү агуу тунхагтай хослуулан тавьсан байна. Энэ тухай Лук 1:26-38 дээр өгүүлдэг. Габриел Мариад Бурхан түүний хэвлийд ер бусын байдлаар хүүтэй болгож, Бурхан Өөрөө хүүхдийн Эцэг болно гэж өгүүлэв. Бурханы Хүүг Есүс гэж нэрлэх бөгөөд энэ нь "Аврагч" гэсэн утгатай. Түүгээр ч зогсохгүй Тэрээр өвөг Давидын хаан ширээг өвлөн авах ба энэ нь Бурханы мөнхийн хаанчлалын авралыг дэлхийд авчрах Давидын агуу хүү Мессиа байх болно гэсэн үг юм.

Мариа, Элизабет хоёр үеэлүүд байсан тул Мариа Иудейд буй Элизабет дээрээ Бурханы хүүг тээж байгаагаа хэлэхээр очжээ. Бид энэ айлчлалын талаар Лук 1:39-56 дээрээс олж уншдаг. Мариа Элизабеттай мэндлэх үед нь Иохан эхийнхээ хэвлийд баярласандаа хөдөлж, Элизабет тэр даруй Сүнсээр дүүрч, хүүхдийнхээ хариу үйлдэл ямар учиртайг ойлгов. Элизабет Мариаг ерөөж, Мариагийн хүүг өөрийн Эзэн хэмээн дууджээ. Үүний хариуд Мариа Лук 1:46-55 дээрх Магнификат гэж нэрлэгддэг алдартай магтаалын дууг дуулж, хүүхдээр нь дамжин ирж буй авралд маш их баярлаж байгаагаа илэрхийлдэг.

Төрөх талаарх тунхгуудын дараа Лук 1:57–2:52 дээр Иохан, Есүс хоёрын төрөлт ба хүүхэд насыг нь харьцуулсан байдаг.

### **Төрөлт ба Хүүхэд нас**

Иоханы төрөлт болон хүүхэд насны талаарх Лукийн тэмдэглэлийг Лук 1:57-80-р эшлэлээс олж болно. Иохан хөгшин настай эцэг эхээс төрсөн. Тэд түүнийг хозлох ёслол хийхээр найм дахь өдөр нь сүмд авчрахад эцгийнх нь хэл яриа эргэн иржээ. Тэр үед Зехариа Ариун Сүнсээр дүүрч, түүний хүү Давидын агуу хүү Мессиагийн замыг бэлтгэнэ хэмээн эш үзүүлсэн байдаг. Лук 1:69-76 дээр Зехариа

Мессиагийн үүргийг хэрхэн дүрсэлснийг сонсоцгооё. Энд:

“Бидний төлөө авралын эврийг Зарц Давидынхаа гэрт Тэр босгожээ. Ариун эш үзүүлэгчдийнхээ амаар Аль эртнээс Түүний айлдсан ёсоор... Эцэг өвгөдөд маань амласан өршөөл бөгөөд, Өөрийн ариун гэрээг санаж... Хөвгүүн, чи Хамгийн Дээд Нэгэний Эш үзүүлэгч гэж дуудуулна. Эзэний өмнө чи явж, замыг нь бэлдэх нь” гэжээ (Лук 1:69-76).

Хуучин Гэрээнд Бурхан Абрахам, Давид хоёрт авралын гэрээний амлалтууд өгсөн. Мөн Зехариа Бурхан эдгээр амлалтыг биелүүлэх гэж байгаа бөгөөд түүний хүү Иохан замыг нь бэлтгэсэн эш үзүүлэгч байх болно гэж зөгнөжээ.

Дараа нь Лук 2:1-52 дээр Лук Есүсийн төрөлт болон бага насны тухай өгүүлсэн. Энэ тэмдэглэл болон түүний өмнөх Иоханы төрөлтийн талаарх хүүрнэл хоёрын хооронд хэд хэдэн ижил төстэй зүйл байдаг. Гэвч Есүсийн төрөлт болон бага насных нь талаарх тэмдэглэл илүү урт бөгөөд илүү нарийвчилсан байдаг. Энэ хэсэг нь Лук 2:1-20-д тэмдэглэгдсэн Давидын хот болох Иудейн Бетлехем хотод Есүс төрж бугаар эхэлдэг.

Есүсийн төрөлт тун эгэл даруу байлаа. Тэрээр малын саравчинд төрж, тэжээлийн тэвшинд өлгийдүүлжээ. Харин ойр орчмын хоньчдод Түүнийг төрснийг тунхагласан тэнгэрэлчүүдийн мэдэгдэл нь сүр жавхлантай байлаа. Лук 2:10-11 дээр тэнгэрэлч хоньчдод юу гэж хэлснийг сонсоцгооё: Энд:

“—Бүү ай. харагтун, би бүх ард түмнийг үлэмж баярлуулах сайхан мэдээг та нарт авчирлаа. Өнөөдөр, Давидын хотод Аврагч Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ” гэжээ (Лук 2:10-11).

Тэнгэрэлч Мессиа Хаан нь Бурханы хүмүүсийг Түүний шүүлтээс аврах болно гэсэн сайхан мэдээ буюу “сайнмэдээ”-г тунхагласан.

Тэгээд Есүс мэндэлсэнд Бурханыг магтан дуулах тэнгэрэлч нарын армитай энэ тэнгэрэлчтэй нэгджээ. Есүс эгэл даруухан төрсөн Мариагийн хүү боловч үнэндээ Бурханы сонгосон Мессиа Хаан байсан гэдгийг Лук тодорхой хэлсэн.

Дараа нь Лук 2:21-40-д Лук Есүсийн хозлох ёслол болон Йерусалимд Эзэнд өргүүлж буй талаар дүрсэлсэн байдаг. Сүмд Ариун Сүнс Симеоныг болоод ариун эш үзүүлэгч Аннаг дүүргэж, хөдөлгөн, Есүс бол дэлхийд аврал авчрах Мессиа мөн гэдгийг тунхаглав. Лук 2:30-32 дээрх Симеоны Бурханд хандсан магтаалыг сонсоцгооё. Энд:

“Учир нь нүд минь Таны авралыг харлаа. Та үүнийг бүх ард олны өмнө бэлджээ. Энэ нь харийнханд илчлэлийн гэрэл, Таны ард түмэн Израилын алдар нь болой” гэжээ (Лук 2:30-32).



Симеоныг гэж хэлэв, "нүд минь Таны авралыг харлаа."

Энэ нь Исаиа 49:6 дээрх Бурханы хэлсэн үгсийн биелэл байсан юм. Энд:

“Тэр "Иаковын овгуудыг босгон, Израилын үлдэгсдийг сэргээхийн тулд Чи зарц минь байх нь өчүүхэн хэрэг. Авралыг минь газрын хязгаарт хүргэхийн тулд Чамайг Би үндэстнүүдийн гэрэл болгоно" гэв (Исаиа 49:6).

Бурхан Симеоноор дамжуулан Есүс бол Израилд аврал ба алдрыг авчрах Мессиа гэдгийг илчилсэн. Түүгээр ч зогсохгүй Тэрээр Бурханы хаанчлалын Сайнмэдээг харь үндэстнүүдэд авчирснаар тэд ч бас аврагдах болно хэмээжээ.

Эцэст нь Лук 2:41-52 дээр сүмд буй Есүсийн тухай товч түүхийг өгүүлснээр Түүний Хүний Хүүгийн талаарх сэдвийг дахин өгүүлдэг. Есүс арван хоёр настай байхдаа Йерусалимын Алгасал баярт эцэг эхээ даган ирсэн боловч тэднийг гэртээ буцахад нь тэднээс салсан байлаа. Эцэг эх нь Түүнийг хэдэн өдрийн дараа сүмд хуулийн багш нартай ярилцаж байхад нь олжээ. Сүмд байсан бүхэн Есүсийн мэдлэг, ойлголтод гайхширч гүйцсэн байв. Мариа Есүст бухимдахад Түүний хариулт Түүнийг ямар онцгой нэгэн гэдгийг нь илчилсэн байдаг. Лук 2:49-д Есүс Мариад юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:

“Эцэгийнхээ гэрт байх ёстойг минь мэдсэнгүй гэж үү?” хэмээжээ (Лук 2:49).

Есүс Бурханы Хүү байсан тул сүм нь Түүний Эцэгийн гэр байв.

Иохан, Есүс хоёрын төрөлт ба хүүхэд насны сэдвийн дараа Лук 3:1-20-д

Есүсийг Иохан таньсан тухай өгүүлдэг.

## Есүсийн Талаарх Иоханы Тунхаглал

Энэ хүүрнэлд Иохан Есүсийг Мессиа хэмээн албан ёсоор тодорхойлсноор Бурханы авралын замыг бэлтгэсэн байдаг. Иохан Иордан голын нутгаар номлон үйлчилж байхдаа Бурханы айсуй хаанчлалыг тунхаглаж, хүмүүсийг нүглээ гэмшихийг уриалж, гэмшсэн хүмүүст баптисм хүртээж байлаа. Гэвч Есүс баптисм хүртэхээр өөр дээр нь ирэхэд Иохан Түүнийг Мессиа хэмээн тунхаглаж, Түүний шаахайг тайлах ч зохисгүй гэдгээ мэдэгдэв. Исаиа 44:3 болон Езекиел 39:29 зэрэг Хуучин Гэрээний эшлэлүүдэд эш үзүүлсний дагуу Есүс Ариун Сүнсээр баптисм хүртэнэ хэмээн Иохан хэллээ. Энэ нь түүхийн эцсийн үе буюу Бурханы аврал бүрэн болох цаг ирсэн гэсэн үг юм.

Хуучин Гэрээнд, ялангуяа Гэтлэл 19-р бүлэгт Бурхан Синаи уулан дээр буун ирж, Израилчууд Түүнийг сонсохоор болдог. Түүнээс өмнө тэднийд хувцсаа угааж, өөрсдийгөө ариусга гэсэн байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүнээс үзвэл цэвэршүүлэн ариусгах нь хүмүүсийг Бурханы ирэлт буюу Түүнийг үзэгдэхэд бэлэн байлгах зорилготой байсан нь харагдаж байна. Хэрэв бид Баптисч Иоханы тунхаглалыг харвал Бурхан шүүхээр ирэх бөгөөд хүмүүс гэмшлээр, тэгээд мэдээж баптисм хүртэх замаар өөрсдийгөө бэлтгэх хэрэгтэй гэдгийг үндсэндээ хэлж байна.

Др. Дэвид А. Ределинс

Сайнмэдээг харвал Иохан хүмүүст баптисм хүртээж байна. Тэгээд дараа нь Есүс Иоханаар баптисм хийлгэхээр ирэхийг бид харна. Яагаад Тэр ингэх болов? Иоханы хувьд гэмшиж, хаанчлалд бэлтгээрэй гэж хэлж байсан. Тэгвэл Есүс гэмших ёстой байсан уу? Мэдээж, үгүй. Тэрээр Бурханы Хүү бөгөөд огтхон ч нүгэлгүй Нэгэн мөн. Тэгтэл яагаад Иоханаар баптисм хийлгэж байна вэ? Тэгэхээр Иоханы баптисм нь хаанчлалын ирэлтэд бэлтгэж байгаа гэдгийг ойлгох нь чухал юм. Тэрээр хүмүүсийг гэмших, итгэхэд уриалж байна. Энэ нь хаанчлал ирж байгаа, тухайлбал Хаан ирж байна гэдгийг зарладаг. Тиймээс энэ нь Христэч баптисм шиг биш байсан гэдэгт итгэлтэй байж болно. Тэд хаанчлалд бэлэн байх ёстой аж. Есүс Иоханаар баптисм хийлгэхээр ирснээрээ одоо Өөрийн үйлчлэлээ эхлүүлж байна. Бүх Сайнмэдээний номуудад Есүсийн үйлчлэл нь баптисмаар эхлэлж буйг харуулдаг. Матайн бичсэнээр Тэрээр бүх зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн тулд бидэнтэй Өөрийгөө адилтгасан байна. Энэ нь Тэр гэмших ёстой учраас биш. Тэр гэмтэн учраас биш. Харин Тэр ард түмэнтэйгээ Өөрийгөө адилтгаж байгаа болохоор тэр юм. Тэгээд Тэрээр олон



нийтийн үйлчлэлээ эхэлж байна. Тэрээр бидний төлөөлөгч болохынхоо хувьд үүргээ гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь Түүний үхэл, амилал, өргөгдөлтөөр оргил цэгтээ хүрдэг. Тиймээс л Тэрээр хүмүүн болон ирж, Иоханаар баптисм хүртсэн юм шүү дээ. Өөрөөр хэлбэл Тэрээр үйлчлэлээ, үйл хэргээ эхлүүлж, Иоханы хүсэн хүлээсэн хаанчлал нь одоо Түүгээр дамжуулан ирж буйг зарлахын тулд байлаа. Тэр бол одоо хаанчлалыг авчирч байгаа Нэгэн мөн.

— Др. Стивен Ж. Вэллум

Бид Есүсийг Иохан хэрхэн таньсан талаар авч үзлээ. Тиймээс одоо Лук 3:21–4:13 дээр буй уг хүүрнэлийн дөрөв дэх буюу сүүлчийн хэсэгт анхаарлаа хандуулцгаая. Энд Есүсийг Бурханы Хүү мөн гэдгийг батлан харуулдаг.

## Бурханы Хүү Гэдгийг Баталсан нь

Лук 3:21-22 дээрх тэнгэрлэг баталгаанаас эхлүүлээд Лук Есүсийг Бурханы Хүү гэдгийг гурван тусдаа байдлаар батлан харуулсан байдаг. Лук 3:22 дээр Есүс баптисм хүртсэн талаар юу гэснийг хамтдаа харцгаая. Лук энд:

“Ариун Сүнс Түүн дээр тагтаа мэт биет хэлбэрээр буун иртэл, тэнгэрээс дуун гарч—Хайрт Хүү минь Чи билээ. Таалал минь Чамд оршдог гэв” гэжээ (Лук 3:22).

Есүсийг баптисм хүртэх үед Сүнс харагдах байдлаар болон тэнгэрээс гарах дуу хоолойгоороо Бурхан Өөрөө Есүс бол Түүний Хүү гэдгийг олон нийтэд баталсан.

Дараа нь тэрээр Лук 3:23-38-д угийн бичгийг бичсэнээрээ Есүс бол Бурханы Хүү гэдгийг баталгаажуулсан.

Матайн нэгэн адил Лук нь Есүсийн угийн бичгийг Давид болон Абрахамын зөвт удмын дагуу бичсэн байна. Гэвч Матайгаас ялгаатай нь Лук хүн төрөлхтний зөвт удмыг бүр Адам хүртэл бүхлээр нь багтааж тэмдэглэлээ өргөжүүлсэн. Энэхүү угийн бичгийн ач холбогдлыг ойлгохын тулд Лук 3:38 хэрхэн төгсдөгийг сонсоцгооё. Тэрээр энд:

“Сет нь Адамын, Адам нь Бурханы хүү болой” гэжээ. (Лук 3:38).

Лук Адамыг "Бурханы хүү" гэсэн нь номын бүхий л бүлгүүдийн туршид Есүсийг тодорхойлсон нэртэй адил байгаа юм. Лук ийнхүү Шинэ Гэрээний бусад хэсгүүдэд тодорхой заасан зүйлийг онцолсон. Бурханы Хүүгийн хувьд Есүс Бурханы анхны хүү болох Адамын зорилгыг биелүүлэх тавилантай байжээ. Эсвэл элч Паул 1Коринт 15:45-д хэлсэнчлэн Есүс нь “Сүүлчийн Адам” байсан байна. Адам нь дэлхий дээр Бурханы хүслийг гүйцэлдүүлэх ёстой Бурханы зарц хаан байсан. Гэвч тэрээр унаж бүтэлгүйтсэн. Харин Есүс бол Адамын бүтэлгүйтсэнийг амжилттайгаар гүйцэлдүүлсэн Бурханы агуу Хүү бөгөөд ингэснээр дэлхийн бүх үндэстэнд авралыг



ӨГСӨН ЮМ.



Адам Бурханы хүслийг биелүүлэх ёстой байсан ч бүтэлгүйтсэн.

Есүсийг Бурханы Хүү гэдгийг харуулах сүүлчийн баталгаа нь Лук 4:1-13 дээр бий. Энд Есүс Өөрийгөө баталсан байдаг. Энэ бол цөлд Есүс соригдсон талаарх түүх юм. Лук 4:1-д тэмдэглэснээр Ариун Сүнс Есүсийг дүүргэж, Сатанд соригдохын тулд цөл рүү хөтөлсөн байдаг. Диавол Есүсийг чулууг талх болгон хувиргаж, диаволоос өөрөөс нь үндэстнүүдийг захирах эрх мэдлийг хүлээн аван, Өөрөө сүмийн орой дээрээс үсэр хэмээн сорьсон. Диавол хоёр сорилтоо “Хэрвээ чи Бурханы Хүү мөн аваас” гэсэн тохуу үгсээр эхлүүлдэг. Хариуд нь Есүс Сатаны гурван сорилтыг эрс няцааж, Бурханы үнэнч хүү хэрхэх ёстой талаарх Хуучин Гэрээний хэсгүүдээс эш татсан байдаг.

Есүс цөлд диаволтой тулгарах үедээ хэд хэдэн шалтгааны улмаас Библиэс эш татсан байдаг. Юуны өмнө Сайнмэдээний бичээчдийн онцолдог нэг зүйл нь Есүсийг Бурханы жинхэнэ Хүү гэдгийг тодотгон харуулах явдал байсан. Тиймээс Түүний Бичвэрээс эш татсан нэг шалтгаан нь Бурхантай байгуулсан гэрээний харилцаатай нь холбоотой байлаа. Тэрээр юмсыг цэгц тодорхой байлгаж, Бурхан Эцэгтэйгээ харилцах харилцаан дотроо Өөрийн эрх мэдлээ зөв зүйтэй харуулахын тулд, мөн диаволын хязгаарлагдмал эрх мэдлийг илчлэхийн тулд ийнхүү Бичвэрээс гэрээний харилцааны талаар эш татдаг. Иймээс Тэрээр хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдрах ёстой гэсэн. Энэ нь гэрээний харилцааны тэргүүлэх ач холбогдлыг Өөртөө сануулахын тулд бөгөөд энэ нь диаволын сорилтыг эсэргүүцэхэд Түүнд тусалдаг. Гэхдээ бид Түүнийг Бичвэрийн

тодорхой нэг хэсгээс, тухайлбал Дэд хууль 6-8-р бүлгээс эш татсаныг харж болно. Учир нь энд Мосе Бурханы хүмүүсийн цөлд амссан туршлагыг, мөн тэнд тэдний зүрх сэтгэлд юу байгааг хэрхэн шалгасан тухай өгүүлдэг. Үүнээс бид нэг төстэй зүйлийг харж байна. Израилын ард түмэн цөлд соригдоод унасан тэрхүү сорилтод Бурханы Хүү унаагүй юм. Тиймээс Сайнмэдээний бичээчид болоод Есүсийн Хуучин Гэрээнээс эш татсан энэ мэт харьцуулалтыг бид Есүсийн сорилтын талаарх хүүрнэлээс ч олж харж болж байна.

— Др. Грегори Р. Пэрри



Есүсийн сорилтыг Адамын сорилттой харьцуулж үзэх хэрэгтэй.

Адамыг Бурханы хүү хэмээн төгссөн Есүсийн угийн бичгийг Лук тэмдэглэсэн учраас Түүний сорилтын талаарх уг түүхийг Эхлэл 3-р бүлэг дэх Адамын сорилттой харьцуулан үзэх нь зүйтэй. Энэ түүхэнд диавол Еден цэцэрлэгт байсан Адамыг сорьсон бөгөөд түүний гэм үйлдэх үед Бурхан бүтээлийг харааж, бүх хүн төрөлхтнийг цөл рүү хөөсөн. Үүний эсрэгээр Есүс цөлд сорилтыг эсэргүүцэн ялсан бөгөөд үүгээрээ Тэрээр үнэхээр Бурханы үнэнч хүмүүсийг тэнгэрийн улсад буцаан авчрах үнэнч Хүү гэдгээ баталсан юм.

Есүс Иудей болон Йорданы нутагт үйл хэргээ эхлүүлсний дараах Лукийн Сайнмэдээний гол хэсэг нь Түүний Галил дахь үйлчлэлийн тухай өгүүлдэг. Энэ хэсэг нь 4:14–9:50 хүртэл үргэлжилдэг.

### ЕСҮСИЙН ГАЛИЛ ДАХЬ ҮЙЛЧЛЭЛ



Лук Сайнмэдээнийхээ энэ хэсэгт Есүс бол Хуучин Гэрээнд амлагдсан Сүнсээр-тослогдсон Аврагч гэдгийг батлахын тулд Түүний гайхамшигт хүч, Сайнмэдээний номлолын олон жишээг өгүүлсэн.

Галил дахь Есүсийн үйлчлэлийг дүрсэлсэн Лукийн хүүрнэлийг таван хэсэгт хувааж болно. Нэгдүгээрт, Назарт айлдсан Есүсийн номлол. Хоёрдугаарт, Түүний сургаал ба гайхамшиг. Гуравдугаарт, Есүс ба Баптисч Иоханы ялгаа. Дөрөвдүгээрт, Есүсийн айлдсан бусад сургаал ба гайхамшигууд. Тавдугаарт, Есүс арван хоёр элчийг үйлчлэлд бэлтгэсэн тухай байдаг. Лук 4:14-30 дээрх Назарт айлдсан Есүсийн анхны номлолоос эхлэн бид хэсэг тус бүрийг авч үзэх болно.

## Назар дахь Номлол

Есүсийн Галил дахь үйлчлэлийн үеэр Түүний гайхамшигт хүч, Сайнмэдээний тунхаглалыг Гурван Синоптик Сайнмэдээ нь бүгдээрээ онцолсон байдаг. Гэвч Лукийн тэмдэглэлийн бусдаасаа ялгаатай нь тэрээр Есүсийн үйлчлэлийн энэ үе хэсгийг Өөрийн төрөлх хот Назарт номлож буйгаар эхлүүлжээ. Лук хэлэхдээ Есүс Амралтын өдөр Синагогт байсан ба Түүнд Исаагийн хуйлмал ном байсан гэжээ. Тиймээс Тэрээр Исаиа 61:1-2-р эшлэлийг уншаад, гайхалтай тунхаглалыг хийсэн байдаг. Лук 4:18-21 дээр Есүсийн уншиж тунхагласан зүйлийг хамтдаа харцгаая. Тэрээр энд:

“Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь ядууст сайнмэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм. Тэр Намайг илгээсэн нь Олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах, Сохруудад хараа оруулах, Дарамтад байгсдыг чөлөөлөхийн сацуу, Эзэний тааламжит жилийг тунхаглахын тулд болой ... —Энэхүү Бичвэр өнөөдөр сонсголд тань биеллээ гэж айлдав” гэжээ (Лук 4:18-21).

Тэрээр энд “Энэхүү Бичвэр өнөөдөр сонсголд тань биеллээ” гэж хэлэхдээ Хуучин Гэрээнд урьдаас бичигдсэн зүйл одоо биелж байна гэсэн юм. Энэ нь чөлөөлөлтийн жилийн тухай байх ба хэрхэн тооцохоос хамааран 49 эсвэл 50 дахь жилд байна. Мосе, Иошуагийн өдрүүдэд Хуучин Гэрээний Израил нь хүмүүсийг өр төлбөрөөс нь чөлөөлж, өвөг дээдсийнх нь нутаг, овгийн газар нутаг, гэр бүлийнх нь газар нутгийг буцааж өгөх ёстой байв. Хэрэв бид Гэтлэлийг Хуучин Гэрээний золилтын томоохон, чухал үйл явдал гэж үзвэл чөлөөлөлтийн жил бол сэргээн босгохын төлөөх Бурханы хангамж байсныг ойлгох хэрэгтэй. Учир нь бид унасан ертөнцөд амьдарч байгаа цагт золилт биднийг аврах болно. Харин сэргээлт нь Бурханы энэхүү золилтын ажлын нэг хэсэг юм. Тиймээс Есүс энэхүү чөлөөлөлтийн жилийг тэмдэг болгон харуулахын тулд ийнхүү хэлжээ. Тэр хүмүүсийг чөтгөрүүдийн дарлалаас чөлөөлж, нийгмийн гадуурхал, ба ялгаварлалаас ангижруулж, тэднийг Бүтээгч Бурхан болох Эцэгт нь буцаан сэргээн өгч байна.

- Рев. Майкл Ж. Глодо

Бурханы хаанчлалын ирэлт нь Бурханы бүх үнэнч хүмүүсийг авралд хүргэнэ гэж Исаиа эш үзүүлсэн. Харин Есүс тэрхүү өдөр нь ирчихээд байна хэмээн тунхаглав. Ийнхүү эш татсан нь Есүсийн бүх үйлчлэлийг илчлэн тайлбарлах Лукийн үндсэн загварыг илэрхийлдэг. Энэ нь Есүс бол Өөрийн хүмүүст аврал авчирснаар энэ дэлхийд Бурханы хаанчлалыг харуулах Хуучин гэрээнд эш үзүүлэгдсэн Мессиа буюу Христ, Аврагч гэдэг нь юм.

Назар дахь Есүсийн номлолын талаар өгүүлснийхээ дараа Лук бээр Есүсийн хүчирхэг сургаал болон гайхамшгуудын хэд хэдэн жишээг Лук 4:31–7:17 дээр өгүүлсэн байдаг.

## Сургаал ба Гайхамшгууд

Лук энэ хэсэгт Есүс Исаиа 61:1-2 дээрх эш үзүүлэгийг биелүүлж байгаа учир үнэхээр Мессиа мөн гэдгийг харуулсан. Лук 4:31-36 дээр Есүс нэгэн хүнийг бузар сүнснээс чөлөөлж буй тухай өгүүлдэг. Тэрээр 4:38-42-г харвал өөр олон хүнийг эдгээсэн байдаг. Лук 5:1-11-т Тэрээр мөн Петр, Иаков, Иохан гэх дагалдагчдаа дуудсан. Мөн 5:12-15 дээр уяман өвчтэй, 5:17-26 дээрх саа өвчтэй хүний эдгээсэн тухай, 5:27-32 дээр дагалдагч Леви буюу Матайг дуудсан зэрэг өмнө дурдсантай төстэй загварыг бид бас олж харна.

Дараа дараагийн эшлэлүүдэд мөн адил хэв маяг давтагдана. Харин Лук эдгэрлийн оронд Есүсийн сургаалуудыг онцлон бичжээ. 5:33-39 дээр Есүс Өөрөө хамт байгаа тул мацаг барих шаардлагагүй бөгөөд баярлан баясах ёстой талаар



заасан. 6:1-11 дээр Есүс Амралтын өдөр нь эдгэрэл ба авралын төлөө байдаг гэжээ. Мөн 6:12-16 дээр Тэрээр олон дагалдагч нараасаа арван хоёрыг нь Израилд шинэ үйлчлэлийг бий болгох үүрэг хүлээсэн Өөрийн онцгой элч нар болгохоор сонгосон.

Есүс эдгээр гайхамшиг, сургаалаараа Өөрийгөө Исаиагийн эш үзүүлсэн Мессиа үнэхээр мөн гэдгээ харуулсан юм. Учир нь Тэрээр эрх чөлөө, эдгэрлийг авчирч, дарлалаас ангижруулан Эзэний тааламж ерөөлийг авчирсан билээ.

Дараа нь Лук Есүсийн айлдсан нэлээд урт номлолыг Лук 6:17-49 дээр өгүүлэв. Энэ номлолыг ихэвчлэн Есүсийн Уулын бэл дэх сургаал гэж нэрлэдэг бөгөөд үүнд Матай 5–7 бүлэгт тэмдэглэсэн Уулын сургаалтай төстэй олон зүйлс бий.

**Матай болон Лук хоёрын сонирхолтой ялгаануудын нэг нь Матай 5–7-р бүлэг дэх Уулын сургаал, Лук 6-р бүлэг дэх "Уулын бэл дэх сургаал" гэсэн сургаалууд юм. Энэ нь дуусахгүй маргаан, мэтгэлцээний сэдэв болдог л доо. Эдгээр сургаалууд нь нэг ижил сургаал уу, эсвэл үгүй юу? Миний бодлоор хоёр зүйлийг дурдах хэрэгтэй. Нэгдүгээрт, бид Есүсийн тухайн үед хэлсэн үгсийн маш багахан хэсгийг л авч үзэж байгаагаа мэдэх ёстой. Би Матай 5–7 бүлгүүдийг хараад, үүнийг чангаар дуудан уншихад магадгүй дөчин минут шаардлагатай байдаг. Есүс олон цагаар, маш олон цагаар ярьж байсан бөгөөд Түүний сургаалыг бүгдийг нь шахаж багтаах боломжгүй юм. Тиймээс бид нэг хэсгээс нь л уншдаг. Тэгэхээр бид адил хэсгийн тухай ярьж байна уу? Тэгэхээр, би бол магадгүй гэж бодож байна. Өөр нэг хэлэх зүйл бол хэрэв та тэр нутгийн газарзүйн байршлыг мэддэг бол энэ нь гайхмаар байдаг. Капернаумын яг ард толгод байдаг тул та тэдгээр толгодыг хараад "За, Есүс суусан, хүмүүс толгод дээр байсан" гэж хэлж болно. Гэхдээ өөр нүдээр хэрэв та үүнийг харвал үнэндээ галт уулын чулуулгийн налуу гулсаа нь далайн түвшнээс гурван мянган тохой өндрөөс эхлэн намссан байдаг. Хэрэв та жаахан алсаас үүнийг харвал энэ нь үнэндээ тэгш тал байна шүү дээ гэж хэлж болохоор байдаг. Тэнд налуу газар байна, тэнд толгод бас байна. Миний хувьд аль аль нь байх боломжтой. Уулан дээрх сургаалын хувьд Есүс уулан дээр сууж байсан, уулын бэлд дэх сургаалын хувьд ч гэсэн яг л адилхан тэгш газар Тэрээр сууж байна гэж хэлж болохоор байна. Энд миний бодлоор эцсийн гол санаа нь үнэхээр гайхалтай. Учир нь Лук Есүсийг бидэнтэй ойр, бидэнтэй хамт байгаа гэдгийг илэрхийлэхийг хүссэн учир түүнийг уулын бэлд буйгаар дүрсэлжээ. Харин Матайн хувьд Синаи уулан дээрх Мосе шиг Есүс уулан дээр байснаар эрх мэдэлтэй заадаг гэсэн агуулгыг бидэнд харуулахыг хүссэн. Тэгэхлээр энэ хоёр хариулт хоёулаа боломжтой гэж би бодож байна.**

— Др. Питер Уолкер

Уулын бэл дэх сургаалдаа Есүс аливаа зүйл эсрэгээрээ эргэж буй талаар өгүүлдэг Исаагийн гайхалтай эш үзүүлэгийг онцолсон. Ядуус ерөөгдөх болно. Өлсөж буй хүмүүс цатгагдах болно. Гашуудан уйлж буй хүмүүс инээх болно. Мөн үл ойшоогдон, тусламжгүй болсон хүмүүс Бурханаар ерөөгдөх ажээ. Гэхдээ энэхүү сайхан мэдээ нь бас цааш нэг алхам ахисан байна. Ерөөлтэй гэж Есүсийн дуудсан хүмүүс Өөрийг нь дагаж, дэлхийн жишгээс тэс өөр байдаг Бурханы хаанчлалын жишиг, үнэт зүйлсийн дагуу амьдар хэмээн дууджээ. Жишээлбэл, харийн хүмүүсээс болгоомжилж, дайснаа үзэн ядахыг заадаг дэлхийн үнэт зүйлээс ялгаатай нь Тэрээр тэднийг харь хүмүүсийг, тэр байтугай дайснуудаа ч хайрла гэжээ. Тиймээс хаанчлалын мэдээ нь зөвхөн ерөөл төдийгүй ёс зүйн хариуцлагыг заадаг.

Уулын бэл дэх сургаалынхаа дараа Лук энэ хэсгийг Есүс Исаагийн эш үзүүлэгийг биелүүлж байсныг нотлох олон баримтаар төгсгөсөн байдаг. Лук 7:1-10 дээр Есүс зуутын даргын зарцыг эдгээжээ. Мөн 7:11-16 дээр Тэрээр Найн дахь бэлэвсэн эмэгтэйн үхсэн хүүг хүртэл амилуулсан.

Галил дахь Есүсийн үйлчлэлийн тухай Лукийн дараагийн түүх бол Лук 7:18-50 дээрх Баптисч Иоханы талаарх бүлэг түүх юм.

## Баптисч Иохан

Баптисч Иохан шоронд хоригдсоныхоо дараа дагалдагч нараа Есүсээс үнэхээр Мессиа мөн эсэхийг нь асуулгахаар илгээжээ. Есүс тэдэнд юу хийснээ сануулж хариулав. Есүсийн гайхамшг ба сургаал нь Исаиа 61:1-2 дээрх эш үзүүлэлгүүдийг тодорхой биелүүлсэн. Иймээс Есүс үнэхээр Мессиа байсан гэдгийг баталсан. Лук 7:22-т Есүс Иоханы элч нарт юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:

“—Та нар явж, Иоханд юу харж, сонссоноо хэл. Хараагүй нь хараа орж, суунги нь алхаж, уямантай нь цэвэршиж, сонсголгүй нь сонсож, үхэгсэд нь амилж, ядууст сайнмэдээ тунхаглагдаж байна” гэжээ (Лук 7:22).

Иохан бол эш үзүүлэгчдийн хамгийн агуу нь гэдгийг Есүс үргэлжлүүлэн нотолсон. Гэвч Иохан хүртэл Бурханы хаанчлал дахь хамгийн өчүүхэнтэй нь ч эн зэрэгцэхгүй хэмээжээ. Лук 7:47-50 дээр Есүс хөлийг нь угаасан нүгэлт эмэгтэйн гэмийг үнэхээр уучилсан гэснээрээ Лук үүнийг тодорхой болгосон байдаг. Иохан хүмүүсийг Бурханаас уучлал гуйн гэмшүүлэхийн тулд баптисм хүртээсэн бол Есүс гэмтнүүдийг уучилж, өвчтэй хүмүүсийг эдгээж, ядууст Сайнмэдээг тунхагласнаар хаанчлалыг хүмүүсийн дунд авчирсан.

Баптисч Иоханы эргэн тойронд өрнөсөн түүхүүдийн дараа Лук 8:1-56 дээр Есүсийн сургаал, гайхамшгуудын талаар илүү ихийг дурдсан байдаг.

## Сургаал ба Гайхамшгууд



Эдгээр нэмэлт сургаал, гайхамшгуудад Есүс хаанчлалын талаарх Сайнмэдээнд анхаарлаа хандуулсан. Лук 8:1-15 дээр тариачны тухай сургаалт зүйрлэл, Лук 8:16-18 дээр дэнлүүний суурийн тухай сургаалт зүйрлэл зэрэгт хаанчлалын мэдээг итгэл, дуулгавартай байдлаар хүлээн авахын чухлыг дүрсэлсэн байдаг. Мөн тэрээр Лук 8:19-21 дээр эдгээр сэдвүүдийг давтаж, Түүний жинхэнэ гэр бүлийн гишүүд бол Бурханы үгийг сонсож, дуулгавартай дагадаг хүмүүс юм гэж хэлсэн.

Дараа нь Лук 8:22-56 дээр Лук Есүсийн авчирсан авралыг баталж, бусдад харуулсан хэд хэдэн гайхамшгийн тухай өгүүлсэн. Эдгээр нь шуургыг намжааж, чөтгөрийг хөөж, өвчтэй эмэгтэйг эдгээж, охиныг амилуулсан зэрэг юм.

Эцэст нь Лук 9:1-50 дээр Есүс арван хоёр элчийг үйлчлэлд бэлтгэсэн тухай өгүүлснээр Галил дахь Есүсийн үйлчлэлийн түүхийг төгсгөсөн байна.

## Арван Хоёр Элчээ Бэлтгэсэн нь

Эхлээд Лук 9:1-9-р эшлэлд Есүс арван хоёр элчээ хүмүүсийг эдгээж, Сайнмэдээг тунхаглуулахаар илгээж буй тухай байдаг. Тэдгээр нь Түүний Лук 6-р бүлэгт тусгаарлан дуудсан хүмүүс нь байв. Дараа нь тэрээр 9:10-17 дээр 5000 хүнийг хооллосноор Өөрийн хүчээ харуулсан юм. Энэ нь Түүний хүч чадал, хангамжид итгэхийг элч нартаа сургасан үйл явдал байв. Эдгээр бэлтгэл нь Лук 9:18-27 хүрээд төгсөх бөгөөд элч нар нь Есүсийг удаан хүлээсэн Мессиа буюу Христ мөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Есүс элч нараа, ялангуяа Түүнийг тэнгэр өөд одсоны дараа хийх үйлчлэлд нь үргэлжлүүлэн бэлтгэж байсан тухай хэд хэдэн түүхээр Лук энэ хэсгийг төгсгөв. Лук 9:28-36 дээр Есүс Петр, Иаков, Иохан нарын өмнө хувирч өөрчлөгдсөн бөгөөд Есүст өөрсдийгөө зориулах зориулалтыг нь бататгахын тулд Эцэг тэнгэрээс хандан ярьсан байдаг. Дараа нь 9:37-45-д Есүс тийм амар хөөгддөггүй чөтгөрийг хөөн харуулж, 9:46-50 дээр хэн хаанчлалд агуу байх тухай заасан байдаг. Эдгээр бүх түүхэнд Есүс дагалдагч нараа Түүний эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, хүч чадалд нь найдаж, Түүний нэрээр даруу үйлчлэгчийн ёсоор үйлчлэхэд нь бэлтгэсэн юм. Ингэснээр тэд дэлхий дээрх Түүний хаанчлалын үр дүнтэй удирдагчид байх болно.

Есүсийн Галил дахь үйлчлэлийнх нь дараах Лукийн сайнмэдээний гол хэсэгт Есүсийн Йерусалим руу аялсан тухай өгүүлдэг. Энэ хэсэг нь Лук 9:51–19:27 дээр гардаг.

## ЕСҮСИЙН ЙЕРУСАЛИМ РУУ ХИЙСЭН АЯЛАЛ



Есүсийн Йерусалим руу явахаар шийдсэн тухай Лук 9:51, 13:22, 17:11, 18:31, 19:28 зэрэг эшлэлүүдэд таван удаа дурдсан байдаг. Нэг жишээ болгон 18:31-32-г сонсоцгооё. Энд:

“Тэр арван хоёрыгоо дэргэдээ авч, тэдэнд —Харагтун, бид Йерусалим руу явж байна. Хүний Хүүгийн тухай эш үзүүлэгчдээр бичүүлсэн бүхэн биелэгдэх болно. Хүний Хүү харийнхны гарт тушаагдахад тэд Түүнийг доромжилж, нулимж, ташуурдсаны дараа ална” гэжээ (Лук 18:31-32).

Энэ мэт хэсгүүдээр дамжуулан ард түмнээ аврах Бурханы төлөвлөгөөнд Есүс үнэнч байсныг харуулжээ. Тэрээр үхнэ гэдгээ мэдэж байсан ч Йерусалимыг зорьсон гэдгийг Лук маш тодорхой харуулсан.

Есүсийн Йерусалим руу аялсан тухай Лукийн яриаг бид дөрвөн үндсэн хэсэгт хувааж үзнэ. Нэгдүгээрт, дагалдагчийн мөн чанарын талаарх Есүсийн сургаал. Хоёрдугаарт, Есүс болон Түүний эсэргүүцэгчдийн хоорондын зөрчил мөргөлдөөний тухай Лукийн мэдээллүүд. Гуравдугаарт, дагалдагч байхын өртгийн талаарх Есүсийн сургаал. Дөрөвдүгээрт, Өөрийн хүмүүсийг аврах Бурханы төлөвлөгөөний төлөөх Есүсийн зориулалт зэрэг юм. Ингээд Лук 9:51–11:13 дээрх дагалдагчийн мөн чанараас эхэлцгээе.

## Дагалдагчийн Мөн чанар

Есүсийн Бурханы хаанчлалыг байгуулж, ард түмнээ аврах зорилго нь Түүнийг онцгой элч нараа сонгон авч, үйлчлэгч удирдагч болгон сургахад хөтөлсөн. Лук 9:51–10:24 дээр Тэрээр Сайнмэдээг хэрхэн тунхаглахыг зааж, тэдний амьдрал

хүнд хэцүү байх болно гэдгийг сануулсан. Гэхдээ Тэрээр мөн тэднийг Ариун Сүнсээр хүчирхэгжүүлсэн. Ийнхүү бэлтгэснийхээ дараа Тэрээр тэднийг очихоор төлөвлөсөн хотууд руугаа Сайнмэдээг тунхаглуулахаар илгээв.

Үүний дараа Лук 10:25–11:13-т Есүс дагалдагч байхтай холбоотой гурван сэдэв болох хөршөө хайрлах хайр, Бурханыг хайрлах хайр, залбирал гэсэн сэдвүүдийг зааж өгснөөр ертөнцийг илүү өргөн хүрээнд харахад нь тусалсан. Есүс Лук 10:27-р эшлэлд хайрын талаарх сургаалаа дараах байдлаар нэгтгэн дүгнэжээ. Энд:

“Чи Эзэн Бурханаа бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч, бүх оюун ухаанаараа хайрла.” Мөн “Хөршөө өөрийн адил хайрла” гэжээ (Лук 10:27).

Энд Есүс Хуучин Гэрээний хууль бүхэлдээ Бурханыг болон хөршөө хэрхэн хайрлахыг бидэнд заадаг гэдгийг тайлбарлахын тулд Дэд хууль 6:5, Левит 19:18-аас эш татсан.

Дараагийн хоёр багц хэсэг нь энэ хайрын талаарх хуулийн хоёр хэсгийг дүрсэлдэг. Эхнийх нь Лук 10:29-37-д гарах "Сайн Самари хүн" сургаалт зүйрлэл бөгөөд энд хөршөө хэрхэн хайрлахыг харуулдаг. Энэ бол хэдийгээр хоорондоо түнжин муу хоёр үндэстэн боловч шархадсан Израил хүнд хөршөө хайрлах хайрыг харуулсан Самари хүний тухай алдартай түүх юм. Дараа нь Лук 10:38-42 дээрх Есүс Мариатай уулзсан түүх нь Бурханаа хэрхэн хайрлах тухай жишээ болдог. Есүсийн хөлд суугаад сургаалыг нь сонссоноор Мариа Бурханаа хайрлахыг амьдралынхаа нэн тэргүүнд тавьж, дуулгавартай сонсох ёстойг бидэнд харуулдаг.

Эцэст нь, Лук 11:1-13 дээр Есүсийн залбирлын талаарх сургаал нь элч нарт өгсөн зааварчилгаагаа төгсгөж, Бурханы хаанчлалын бэлэг, ерөөлүүдийн төлөө чин сэтгэлээсээ, тууштай залбирахыг заажээ.

Христитгэгчдийн хувьд залбирал маш чухал юм. Энэ бол Есүсийн амьдралын чухал хэсэг байсан бөгөөд бид үүний ач холбогдлыг Түүний амьдралын жишээнээс харж болно. Тэрээр завгүй их үйлчлэлтэй байх тусмаа илүү их залбирч, амарч байхдаа Бурханы хүч чадлыг эрэлхийлдэг байсныг бид олж хардаг. Тэрээр Өөрийгөө сүнс дотор шинэчлэхийн тулд Эцэгтэйгээ байнга харилцах хэрэгтэй гэдгээ мэдэж байлаа. Тэрээр арван хоёр дагалдагчаа сонгохоосоо өмнө шөнөжин залбирч, тэдний нэг нь Өөрөөс нь урвана гэдгийг ч мэдэж байв. Үнэндээ Тэр дагалдагч нараа сонгохдоо угтаа загалмайг харж байсан юм. Энэ нь Есүс маш чухал үйлчлэлийг хийхээсээ өмнө шөнөжин залбирсан шалтгааных нь нэг мөн. Есүсийн залбирлын амьдрал бол бидний хувьд үлгэр жишээ юм. Хожим дагалдагч нар нь гайхамшигт үйлсийнхээ төлөө баяр хөөртэй буцаж ирэхэд Есүс Эцэгийг магтаж, “-Эцэг Тандаа талархъя, тэнгэр газрын Эзэн минь! Цэцэд хийгээд ухаантаас нууцалсан зүйлээ балчир хүүхдүүддээ илчлэв” гэсэн байдаг. Есүс Эцгийг магтсан тул бид ч бас Түүнийг магтах ёстой. Хэрэв Есүс

хүртэл залбирч, магтах шаардлагатай байсан юм бол бид бүр ч илүү байх ёстой. Тэрээр баривчлагдахынхаа өмнө Гетсемани цэцэрлэгт чин сэтгэлээсээ залбирч, эцэст нь “Эцэг минь, хэрэв Та хүсэж байгаа бол энэ аягыг Надаас холдуулаач. Гэвч Миний хүслээр бус, харин Таныхаар болог” гэсэн. Эндээс Есүс Эцэгтээ бүрэн захирагдаж байсныг бид харж болно. Есүс Эцэгтэйгээ харилцаатай байсан тул Түүнд залбирч, хүн төрөлхтний авралын төлөвлөгөөг бүрэн дуусгахыг хүссэн. Түүний энэхүү жишээ нь Бурханы хүүхдүүдийн хувьд бид залбирч, Эцэгийн хүсэлд захирагдах нь амьдралд маань амин чухал гэдгийг заадаг.

— Др. Питер Чоу, орчуулга

Христитгэгчид залбирах нь чухал байдгийн гол шалтгаан бол бид залбирах бүрдээ Христэд итгэж буйгаа мөн Сайнмэдээний үнэн дотор амарч байгаагаа илэрхийлж байдаг явдал юм. Бидний залбирах цорын ганц шалтгаан бол Есүс бидний нүглийн төлөө үхсэн явдал юм. Есүс бидэнд Бурханы сэнтийн өмнө очих боломжийг нээсэн. Есүс бидний тийшээ очих замыг нээж өгсөн учраас бид залбирлаар итгэлтэйгээр нигүүлслийн хаан сэнтийд зоригтойгоор очиж чадна. Тиймээс бидний залбирдаг эхний шалтгаан бол Сайнмэдээг хүлээн авч итгэсэнд байдаг юм шүү дээ. Бидний залбирдаг хоёр дахь шалтгаан бол энэ нь бүх зүйл Бурханаас хамааралтай гэдгийг тасралтгүй илэрхийлж байдаг юм. Бид хүүхдүүдээ ерөөх дуртай аавтай адилхан Түүн рүү очиж өдөр тутмынхаа талхаа гуйдаг. Гэхдээ энэ нь бас Бурханыг хүндэтгэн мөргөх, Түүний үнэ цэнийг бишрэх, Түүнтэй нөхөрлөх арга зам юм. Тэр бол Бурхан бөгөөд амьдралд маань эрхэм чухал Нэгэн гэдгийг ухамсарлан, өдөр бүр түүний оршихуйд алхаж буйгаа мэдрэхийг залбирал дотор байх явдал юм хэмээн Библи хэлдэг.

— Др. К.Эрик Тоеннес

Жон Вэсли залбирлыг Бурханд ойртох гол хэрэгсэл, нигүүлслийн тэргүүн арга зам гэж нэрлэсэн. Чухамдаа Христитгэлийн түүхийг харахад Бичвэр унших, залбирах нь сүнслэг байдлын хоёр үндсэн сахилга бат юм. Залбирал нь яагаад ийм чухал байдаг вэ гэвэл энэ нь Христитгэлийн гол хөгжүүлэх ёстой зорилго болох Бурхантай маш дотно харилцааг бий болгодог зүйл гэж би боддог. Бид залбирах үедээ Бурхантай ярилцаж, Бурханы бидэнд хэлэх зүйлийг сонсож, дараа нь сонссон зүйлдээ хариу үйлдэл үзүүлдэг. Мөн энэ нь харилцааны үндэс суурь юм. Энэ бол үнэхээр Бурханы

биднээс хүсдэг зүйл буюу Өөртэй нь харилцаатай байх явдал юм. Бурхан цэцэрлэгт алхаж, Адам, Ева хоёртой нөхөрлөхийг хүссэн байдгийг та Эхлэл номоос харна. Залбирал нь бидний Бурхантай алхаж, ярилцах арга зам болдог. Хуучны магтуунд "Эзэн минь надтай алхан ярилцаж, намайг найзаа болгосон юм" гэдэг. Та залбирахдаа Христитгэлийн зүрхэнд юу байх ёстойг хийж байдаг. Яагаад гэвэл энэ нь чухамдаа харилцаа юм шүү дээ.

— Др. Стив Харпер

Дагалдагч байхын мөн чанарын талаарх Есүсийн сургаалын дараа Лук 11:14–15:32 дээр Есүс болон Иудейн удирдагчдын хоорондох зөрчилдөөн улам ширүүсэж буйг онцолсон байдаг.

## Эрчимжиж буй Эсэргүүцэл

Аяллынхаа энэ хэсэгт Есүс дор хаяж гурван шалтгааны улмаас Иудейн удирдагчдыг санаатайгаар эсэргүүцсэн байдаг. Нэгдүгээрт, тэд Бурханы ард түмнийг ядмагхан удирдаж буйг нь зэмлэхийг хүссэн. Хоёрдугаарт, Тэрээр хүмүүсийг Өөрийн хаанчлалд дуудахыг хүссэн. Гуравдугаарт, Тэрээр Өөрийгөө тэд нараар Йерусалимд цовдлуулах зорилготой байсан. Тэгж байж Тэрээр ард түмнийхээ нүглийг цагаатгаж, тэдний Хаан болох ёстой байлаа.

Тухайлбал, Лук 11:14-28-т өгүүлснээр Иудейчүүд Есүсийг "чөтгөрүүдийн захирагч" гэцгээж байв. Үүний хариуд Есүс 29-53 дээр тэдний ёс бус үйлдлийг буруушааж, тэднийг золгүй еэ хэмээн тунхаглав.

Лук 12:1-3-т Есүс хурсан олонд фарисайчууд шиг хоёр нүүрт байж болохгүйг анхааруулсан. Мөн 4-21-р эшлэлд Тэрээр Иудейн синагогууд, захирагчид, эрх баригчдын зан үйлийг буруутгасан байдаг. Үүнчлэн 22-32 дээр Тэрээр Бурханы хаанчлалыг эрэлхийлсэн хүн бүрийн хэрэгцээг Бурхан хангах төдийгүй, ингэснээр тэд Иудейн удирдагчид шиг дэлхийн баялгийг эрэлхийлэх шаардлагагүй болно гэдгийг онцолжээ. Мөн 33-59-р эшлэлд Есүс дагалдагчид нь Бурханы хаанчлалыг хүлээн аваагүй хүмүүстэй зөрчилдөх нь гарцаагүй гэдгийг анхааруулсан.

Лук 13:1-9-р эшлэлд Есүс бүх Израилыг нүглээ улайхад уриалснаараа Иудейн удирдагчдыг үргэлжлүүлэн эсэргүүцэв. Дараа нь 10-17 дээр Тэрээр Амралтын өдөр бөгтөр эмэгтэйг эдгээж, синагогийн захирагчийг уурлуулснаар зөрчлийг улам дэвэргэсэн байдаг. Мөн 18-30-р эшлэлд Есүс Бурханы хаанчлалд өөрсдийгөө орно гэж бодсон олон хүн орохгүй хэмээн зааж, Иудейн гол удирдлага болон тэдний дагалдагчдыг илт буруушаав. Эцэст нь 31-35-р эшлэлд Есүс болон Түүнийг алахаар төлөвлөж байсан Иудейн хаан Херод хоёрын хооронд хурцадмал байдал үүссэн тухай Лук өгүүлжээ.

Лук 14-р бүлэгт Есүс Иудейн удирдлагыг улам өдөөн хатгав. Тэрээр 1-24-р эшлэлд Амралтын өдөр нэгэн хүнийг эдгээж, дараа нь тэдгээр удирдагчдын

дэлхийлэг үнэт зүйлсийг шүүмжилжээ. Тэр ч байтугай тэдний хэн нь ч Бурханы хаанчлалыг өвлөхгүй хэмээн өгүүлжээ. Дараа нь 25-34-р эшлэлд Есүс дагалдагчдадаа Өөрийг нь эсэргүүцэгчдийн энэхүү зөрчлийн улмаас энэ амьдралын бүх зүйлсээ тэд алдаж магадгүй гэдгийг анхааруулсан.

Тэгээд 15:1-2 дээрх оршил үгсийн дараа Есүс алдагдсан хонь, алдагдсан зоос, алдагдсан хүүгийн тухай сургаалт зүйрлэлүүдээр дамжуулан иудейн удирдагчидтай дахин зөрчилдсөн. Түүх бүрдээ Тэрээр ард түмнээ фарисайчууд болон хуулийн багш нарын хоёр нүүрт байдлаас татгалзаж мөн Бурхан хүүхдүүдээ дэлхийн төөрсөн гэмтнүүдийн дундаас олох үед нь баярлан баяс хэмээн ятгаж байв.

Дагалдагч байхын мөн чанарын талаарх Есүсийн сургаал болон Иудейн удирдагчидтай улам бүр зөрчилдөж буй тухай тэмдэглэснийхээ дараа Лук 16:1–18:30 дээр Лук бээр Есүсийн Йерусалим руу хийсэн аялал ба дагалдагч байх үнэ өртгийн тухай өгүүлсэн байдаг.

## Дагалдагч Байх Өртөг

Есүс дагалдагчдадаа Түүний хаанчлал дахь амьдрал нь Өөрийнх нь амьдралын хэв маягтай адил байх болно гэдгийг ойлгуулахыг хүссэн. Тэд дэлхийлэг удирдагчдад хавчигдан, Бурханд үнэнч үлдэхийн төлөө зөрчил тэмцэлтэй тулгарах болно. Есүс 16:1–17:10 дээр дагалдагч байх нь бидний эзэмшиж буй бүх зүйлсийг Бурханы хэмээн харахыг хэлэх бөгөөд бид нярав нь байж, эдгээрийг зорилгынх дагуу ашиглахыг хэлэх ажээ. Тэрээр мөн энэ дэлхийн ерөөлүүд нь баячуудыг жинхэнэ Сайнмэдээг таньж, хүлээн авахад нь саад болж, бүдэрч болзошгүйг анхааруулсан. Эцэст нь Тэрээр итгэл ба гэмшлийг урамшуулж, бид хэчнээн сайн зүйл хийсэн ч бидний хамгийн сайн нь Бурханы шаардлагад хүрдэггүй гэдгийг батлан хэлжээ.

Тэгээд Есүс 17:11–18:8-д энэ дэлхийн эцсийн шүүлтэд анхаарлаа хандуулсан байдаг. Энэ амьдралдаа бидний хүлээн авдаг сайн сайхныг зүйлс болох эрүүл мэнд, эд хөрөнгө, шударга ёс зэрэг нь Бурханы сайн сайхныг бидэнд харуулах ёстой бөгөөд энэ амьдралд маань биднийг үүгээр ерөөхийн төлөө бид залбирах хэрэгтэй гэжээ. Гэвч тэдгээр нь эцсийн шүүлтэд бүгд устаж үгүй болох тавилантай аж. Жинхэнэ эд баялаг, эрүүл мэнд, шударга ёс нь зөвхөн Бурханы мөнхийн хаанчлалд шагнал болж ирдэг тул бидний найдвар үүнд л байх ёстой.

Эдгээр санаагаа Есүс Лук 18:9-30 дээр даруу байх хэрэгтэйг онцлон тэмдэглэснээр төгсгөсөн. Учир нь зөвхөн даруу хүмүүс л Бурханы уучлал, ерөөлийг хүлээн авч, мөнх амьдралыг өвлөн авах болно.

Лук 18:31–19:27-д Лук ард түмнээ аврах Бурханы төлөвлөгөөнд Тэрээр үнэнч байгааг нь онцолсноор Йерусалим руу хийсэн Есүсийн аяллын түүхийг дуусгажээ.

## Есүсийн Зориулалт

Лук 18:31-34-т Есүс Өөрийнхөө үхлийг зөгнөснөөр Бурханы төлөвлөгөөнд өөрийгөө зориулж буйгаа анх харуулсан байдаг. Есүс ард түмнээ аврахын тулд үхэх



ёстойгоо мэдэж байсан бөгөөд Эцгийнхээ төлөвлөгөөг бүрэн дагахаар шийдсэн.


Үүний дараагаар Есүс аврахаар ирсэн хүмүүсээ ерөөснөөрөө Бурханы авралын төлөвлөгөөнд өөрийгөө зориулж байгаагаа харуулсан. Тухайлбал Тэрээр Лук 18:35-43 дээр сохор хүнийг эдгээж, Лук 19:1-10 дээр татвар хураагч Закхайг дуудсан байдаг. Эдгээр хүмүүс ихэвчлэн нийгмээсээ орхигдсон байлаа. Гэвч Исаиа 61:1-2 дээрх амлалтын дагуу тэд Бурханы хаанчлалд агуу өвийг хүлээн авах болно. Лук 19:9-10 эшлэлүүдэд Есүс Закхайн тухай ийнхүү өгүүлжээ. Энд:

“Өнөөдөр энэ айлд аврал ирлээ. Учир нь тэр ч гэсэн Абрахамын хүү мөн. Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ” гэжээ (Лук 19:9-10).

Эцэст нь Есүс Лук 19:11-27 дээр хаан эзгүй үедээ мөнгө хөрөнгөө даатгасан зарц нарын тухай сургаалт зүйрлэлийг өгүүлсэн. Энэ сургаалт зүйрлэл нь хэрэв бид Бурханы хаанчлалд өв залгамжлахыг хүсвэл Есүс шиг Бурханы төлөвлөгөөнд өөрийгөө зориулах ёстойг харуулсан.

Есүсийн Йерусалим руу хийсэн аяллынх нь тухай өгүүлээд Лук Түүний Йерусалим дахь үйлчлэлийн талаар тэмдэглэсэн. Энэ бол Лукийн Сайнмэдээний тав дахь гол хэсэг бөгөөд энэ нь 19:28–21:38 хүртэл үргэлжилдэг.

## ЕСҮСИЙН ЙЕРУСАЛИМ БА ЭРГЭН ТОЙРОН ДАХЬ ҮЙЛЧЛЭЛ



Есүсийн Йерусалим дахь үйлчлэлийн талаарх Лукийн тэмдэглэл нь Йерусалимд орж ирэх үед цугласан олон уухайлан, магтаж угтан авч буйгаар эхэлдэг. Энэ тухай Лук 19:28-44 дээр өгүүлдэг. Есүс хотод орж ирснийхээ дараа хийсэн анхны үйлдэл нь сүмийг цэвэрлэн, худалдаачдыг хөөсөн явдал байв. Энэ үйл явдал Лук 19:45-46 дээр гардаг. Ийнхүү сүмийг цэвэрлэсэн нь Иудейчүүдийн амьдрал ба хүндлэл мөргөлийг завхруулсан гэмт үйлдлүүдийг буруушааж, улмаар Иудейн удирдагчдыг тун хатуу шүүмжилсэн хэрэг байлаа.

Хуучин Гэрээний түүхэн нөхцөл байдал нь бидэнд Шинэ Гэрээний олон сургаалыг ойлгоход хэрэгтэй байдаг шиг Есүсийн сүмийг цэвэрлэсэн үйл явдлыг ойлгоход ч мөн хэрэгтэй. Бид Хуучин Гэрээ рүү буцан очиж судлах хэрэгтэй. 1Хаад 8-р бүлэгт сүмийн сүмийг эзэнд өргөсөн тухай өгүүлдэг. Сүм хэдэн жилийн турш баригдсан юм. Тэгээд дуусмагц Соломон хаан болон израилын ард түмэн сүмийг Эзэнд өргөхөөр цуглав. Соломон хаан Бурханд хандан "Энэ газарт хандсан Таны боол болон Таны ард түмэн Израилын гуйлтыг Та сонсооч. Тэнгэр дэх Өөрийнхөө залрах газраас сонсооч, анхаарч өршөөн соёрхооч." Түүнчлэн Соломон хаан Бурханы агуу нэрийг сонссон харь хүмүүс алс газраас ирж, сүмд залбирахаар ирэхэд нь Бурхан тэднийг сонсооч хэмээн залбирчээ. Тийнхүү дэлхийн бүх хүмүүс Түүний нэрийг мэдэж, Түүнээс эмээх бөгөөд сүм нь Бурханы нэрийн төлөө баригдсан гэдгийг мэднэ гэв. Тиймээс Есүсийн үед шашны эрх баригчид сүмийг дээрэмчдийн үүр болгосон нь Бурханы нэрийг гутаасан явдал байсан юм. Яагаад гэвэл сүм нь Бурханы нэр алдартай салшгүй холбоотой байв. Цаашилбал Есүс сүмийг цэвэрлэсэн нь бэлгэдлийн утгатай байсан. Сүм нь Есүсийг Өөрийг нь зааж байсан. Учир нь Тэрээр жинхэнэ бөгөөд эцсийн сүм юм. Бид нэгэнт Есүсийн нэрээр Эцэгт залбирдаг тул Есүс бол бүх үндэстэн залбирахаар ирдэг тэрхүү сүмийн бодит байдал мөн. Тиймээс хэрэв бид Хуучин Гэрээний сүмийн талаар сайн ойлговол сүмийг цэвэрлэж байгаа нь хэр чухал болохыг, мөн Бурханы хаанчлалын ирэлттэй ямар холбоотой болохыг нь харж чадна.

— Др. Петр Чоу, орчуулга

Есүсийг хамгийн их уурлуулсан зүйл нь сүмд харь үндэстнүүдэд зориулсан хэсэг талбай л байсан явдал байв. Тэнд үндэстнүүд ирж, орчлон ертөнцийг Бүтээгчийн оршихуйд байдаг байлаа. Тэд Иудейчүүдэд л зориулагдсан гэх сүмийн дотоод хэсэгт орж чаддаггүй байв. Харин гаднах хашаа нь л үндэстнүүдэд буюу харь хүмүүст зориулагдсан байжээ. Тэд ирж, тэнд залбирч болно. Гэтэл тэнд угтаа залбирах газар байсангүй. Тэнд сүмийн жинхэнэ зорилго болох харь үндэстнүүдэд зориулсан газар үгүй байв. Тиймээс л Есүс сүмийг дахин босгож, үндэстнүүд ирж залбирах боломжтой тэрхүү орон зайг бий болгон дахин шинэчилж байгаа нь тэр байлаа.

— Др. Грегори Р. Пэрри

Бид Лук 19:47–21:38 дээрээс харвал Есүс дараагийн хэдэн өдрийг сүмийн талбайд зааж, Бурханы хаанчлалын тухай өгүүлсэн байдаг. Энэ хугацаанд Тэр Иудейн удирдагчдын үйлдлийг буруушааж, тэд харин Түүний эрх мэдлийг зөвшөөрөхгүй зөрсөөр тэдний зөрчилдөөн улам ширүүссэн. Лук 20:20-д хуулийн багш нар болон ахлах тахилч нар хэрхсэнийг хамтдаа сонсоцгооё. Энд:

“Тэд Түүнийг ажиглан, Түүнийг үгэн дээр нь урхидан барьж, захирагчийн гарт тушаах зорилготой, зөвт мэт дүр эсгэгч туршуулуудыг Түүн рүү явуулав” гэжээ (Лук 20:20).


Гэвч Есүс ёрын хүмүүс Өөрийг нь урхинд оруулахыг оролдож байсан ч үнэнийг номлохоо зогсоосонгүй. Харин ч тэднийг ил цагаан зэмлэсэн. Тэрээр Лук 20:46-47 дээр цугласан олонд хандан ийнхүү өгүүлэв. Энд:

“Хуулийн багш нараас сэрэмжлэгтүн. Тэд урт дээлтэй явж, гудамж зээл дээр хүндлүүлэн мэндлүүлэх дуртай. Мөн тэд синагогуудад тэргүүн суудалд, найран дээр хойморт залрах дуртай. бэлэвсэн эмэгтэйчүүдийн гэр орныг цөлмөж, удаан залбирч буй дүр үзүүлдэг. Эдгээр нь үлэмж хүнд ял хүртэнэ” гэжээ (Лук 20:46-47).

Есүс Йерусалимд ойртоход Израил Түүнийг аврагч Мессиа гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан нь Түүнийг хотын сүйрлийг эш үзүүлэхэд хүргэв. Гэхдээ энэ сүйрэл ч гэсэн илүү агуу шүүлтийн урьдчилгаа төдий л байх аж. Эцсийн өдөр Есүс сүр жавхлангаараа эргэн ирэхэд хүн бүр Түүний өмнө тайлагнана. Энэ шалтгааны улмаас Есүс эрин үе болгонд дагалдагч нараа Өөрийг нь уйгагүй дагаж, эргэн ирэхийг нь сэрэмжтэй байн хүлээгээрэй гэсэн байдаг.

Йерусалим дахь Есүсийн үйлчлэлийн талаар бид харлаа. Одоо Лукийн Сайнмэдээний сүүлчийн гол хэсэг болох Лук 22:1–24:53-т буй Есүсийн Йерусалимын гадна цовдлогдож, тэгээд амилсан талаарх хүүрнэлд анхаарлаа хандуулцгаая.

## ЕСҮСИЙН ЦОВДЛОЛ БА АМИЛАЛ



Лук Сайнмэдээнийхээ энэ хэсэгт Есүс ард түмнийхээ авралыг үнэндээ хэрхэн гүйцэлдүүлснийг тайлбарлав. Тэр Өөрийгөө эвлэрүүллийн тахил болгон өргөснөөр тэнгэрлэг Эцэгийнхээ төлөвлөгөөг биелүүлсэн. Мөн эцэг Давидын нь хаан сэнтий түүнийх болсон тул одоо Өөрийн ард түмнийхээ хаан болж, захирч байна.

Есүсийн цовдлол ба амиллын талаарх Лукийн тэмдэглэлийг хоёр хэсэгт хувааж болно. Эдгээр нь Есүс баривчлагдан шүүгдээд, үхсэн тухай болон амилж, тэнгэр өөд одсон тухай байна. Эхлээд Лук 22:1–23:56 дээрх Есүсийн баривчлагдан шүүгдээд, үхсэн талаар хамтдаа харцгаая.

## Баривчилгаа, Шүүлт ба Үхэл

Есүсийн баривчлагдан шүүгдээд, үхсэн талаарх тэмдэглэл нь Лук 22:1-6 дээр буй урвах хуйвалдаанаар эхэлдэг. Тэгээд Есүс 7-38-р эшлэлд Сүүлчийн зоогийн үеэр Иудас Өөрөөс нь урвана хэмээн эш үзүүлсэн тухай, мөн Петр Есүсийг дагадаг гэдгээ үгүйсгэх талаар өгүүлдэг. Гэвч эдгээр гунигт эш үзүүлэгүүдийн дунд Тэрээр Өөрийн хаанчлалд дагалдагч нарынх нь эзлэх байр суурийг батлан өгүүлж, энэ бүх үйл явдал нь түүний удирдлага дор байгаа гэжээ.

Сүүлчийн зоогийн дараа бид Лук 22:39-46 дээрээс Чидун уулан дахь Есүсийн залбирлыг олж хардаг. Есүс энэ залбирлын үеэр маш их шаналж, хэрэв боломжтой бол загалмайт өөрөөс нь зайлуулаач хэмээн хүсэж, хөлс нь цус болон дусалж байсныг бид харж болно. Гэвч энэ бүхний туршид Есүс тэнгэрлэг Эцэгтээ итгэх бат итгэлдээ болон Эцгийн төлөвлөгөөнд өөрийгөө зориулахдаа хэзээ ч эргэлзэн ганхаагүй юм.

Лук 22:47-53 дээрх Есүсийн баривчилгаа нь Петр Есүсийг үгүйсгэхэл хүргэсэн талаарх 54-62-р эшлэлд өгүүлдэг. Ийнхүү Есүс баривчлагдаад иудейчүүдийн удирдагчид, Пилат мөн Херод нарын өмнө Есүсийн шүүгдсэн. Энэ тухай 22:63–23:25 дээр бичсэн байдаг. Херод, Пилат хоёр хоёулаа Есүсийг Ромын эсрэг ямар нэг үхвэл

зохих гэм үйлдээгүй гэж үзсэн. Гэсэн хэдий ч Пилат Иудейчүүдийн удирдагчид болон олон түмний дарамтад орж, гэм зэмгүй Есүсийг цовдлохыг зөвшөөрсөн юм.

Есүсийг шүүгдэж, үхэхэд олон түмэн Түүнд хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн талаар Сайнмэдээний номуудаас уншаад хүмүүс заримдаа гайхаж хоцордог. Учир нь Есүс Пилаттай хамт олон түмний өмнө зогсох үед тэд Түүнийг үхүүлж, Барабыг суллахыг шаардсан байдаг. Нэг хариулт нь бид хүний гэм нүглийн завхрал хэчнээн гүн болохыг санаж байх ёстой. Яагаад гэвэл хүмүүс бид гэмтэй, бас шударга бус явдалд амархан өртөмтгий байдаг. Тухайн үед уг үйлдэл нь бидэнд хамгийн тухтай эсвэл биднийг алдартай болгох юм шиг санагддаг. Тиймээс л бид бурууг үйлдэх юм уу эсвэл олныг даган сэтгэл хөдлөлд автах нь амархан байдаг. Эсвэл бид зүгээр л буруу зүйл хийх хандлагатай байдаг. Есүсийг шүүгдэх үед нэг иймэрхүү зүйлс тохиолдсон байх гэж би бодож байна. Бидний санаж байх ёстой өөр нэг зүйл бол тэнд байсан олон хүмүүс үнэндээ Есүсийн эсрэг хатуу байр суурьтай байсан фарисайчуудтай санал нийлж байсан хүмүүс байсан байж ч магадгүй юм. Есүсээс айж байсан ахлах тахилч нар Ромчууд тэдний эрх мэдлийг булаана, хэрэв тэд Есүст ямар нэг арга хэмжээ авахгүй бол улс төрийн хувьд Ромчуудын өмнө асуудалд орох болно гэж айж байв. Тэгэхээр нэг талаас та тэдний маш хулчгар үйлдлийг олж харна. Нөгөө талаар өөрсдийгөө зориггүй биш гэж үзэх фарисайчууд нь Есүсийг зүгээр л теологийн хувьд буруу гэж эсэргүүцэж, Түүнээс салахыг хүссэн хүмүүс бас байсан. Тиймээс цугларсан олон хүмүүс нь бүх хүмүүсийг төлөөлөхгүй боловч Есүсийг эсэргүүцдэг хүмүүстэй санал нийлж байсан бүлэг хүмүүс байсан байх нь ээ. Чуулган байгуулагдсан анхны үеийн Христитгэгчид бүгд иудейчүүд байсан. Элч нар нь иудей, Есүс Өөрөө иудей байсан. Тийм болохоор Есүсийн талаар эерэг хандлагатай олон иудейчүүд байсан гэдгийг санах нь бидний хувьд маш чухал юм. Тэгэхээр загалмайд Түүнийг цовдол гэж хашхирч байсан хүмүүс нь Есүсийн үйлчлэлийн үеэр байсан хүмүүсээс багахан хэсэг нь байсан байж магадгүй юм.

— Др. Фрэнк Тиелман

Сонирхолтой нь Есүсийн баривчилгаа болон шүүх хурлын талаарх Лукийн хүүрнэл нь Есүсийн ирэх үхлийн тухай биш, харин Түүний Христ мөн болох талаар онцолсон байдаг. Лук 22:67-70-р эшлэлд буй Есүс болон Иудейн удирдагчдын хоорондох яриаг сонсоцгооё. Энд:

“Тэд —Хэрэв Чи Христ мөн юм бол бидэнд хэлээдэх гэхэд Тэр —Би хэлбэл та нар итгэхгүй... Харин үүнээс хойш Хүний Хүү Бурханы сүр хүчний баруун талд залрах болно гэжээ. Тэд бүгд —Чи тэгээд Бурханы



Хүү юм уу? гэсэнд Тэр тэдэнд —Би мөн гэдгийг та нар хэлж байна гэв” гэжээ (Лук 22:67-70).

Энэ багц хэсэгт Есүс Өөрийгөө Христ, Хүний Хүү, Бурханы Хүү гэж тодорхойлжээ. Эдгээр бүх нэр томьёо нь Түүнийг Хуучин Гэрээнд эш үзүүлэгдсэн Мессиа гэсэн баримтыг тодотгодог.

Тэрээр шүүгдсэнийхээ дараа хэрхэн цовдлогдсон тухай Лук 23:26-49-д дүрслэгдсэн байдаг. Ингэхдээ Лук 43, 46-р эшлэлүүдэд Есүсийн загалмай дээр хэлсэн үгсээс Сайнмэдээний бусад бичээчдийн хэн нь ч бичээгүй үгийг хоёр удаа дурдсан. Эдгээр үгс Лукийн Сайнмэдээндээ дахин дахин онцолсон хоёр санааг нь тодруулж байна. Нэгдүгээрт, Есүс тусламж хэрэгтэй хүмүүсийг энэрэх сэтгэлээр дүүрэн байсан. Хоёрдугаарт, Есүс эдгээр бүх үйл явдлыг удирдаж байсан Эцэгтээ бүрэн итгэсэн юм. Лук 23:43 дээр Есүс хажуугийн загалмай дээрх хулгайчийг өрөвдөн, ийнхүү тайвшруулдаг. Тэрээр энд:

“Үнэнээр Би чамд хэлье. Өнөөдөр чи Надтай хамт диваажинд байх болно” гэжээ (Лук 23:43).

Мөн 46-р эшлэлд Есүс Өөрийн Эцэгтээ итгэж буйгаа илэрхийлэн ийнхүү хэлжээ. Тэрээр энд:

“Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая” гэжээ (Лук 23:46).

Лук бидний Эзэний амь тавихаасаа өмнөх сүүлчийн мөчдөө бусдыг энэрч, Эцэгтээ итгэх итгэлээр дүүрэн байсныг тун тодорхой харуулсан. Дараа нь Лук бичихдээ Амралтын өдөр болох гэж байсан тул Есүсийн шарилыг нь оршуулахад бэлтгэлгүйгээр хадан булшинд оршуулсан гэжээ. Энэ нь 23:50-56 дээр бий.

Лукийн хавчигдаж байсан уншигчид Есүсийн зовлон зүдүүртэй хэрхэн холбогдож, ойлгож байсныг төвөггүйхэн харж болно. Тэд ямар ч хавчлага зовлонг тэвчсэн байлаа гэсэн Есүс түүнээс нь хавь илүүг даван туулсан байв. Түүнээс гадна Тэрээр энэ бүхнийг тэдний төлөө хийсэн. Хэрэв тэдний Эзэн тэдний төлөө зовж шаналж, бүр үхэхэд ч бэлэн байсан бол тэд түүний төлөө зовж шаналж, үхэхэд бэлэн байх нь гарцаагүй. Гэхдээ энэ нь зүгээр нэг өр төлөөс төдий биш юм. Яг л Есүсийн дуулгавартай байдал, зовлон нь шагналд хүргэсэнтэй адил Түүний дуулгавартайгаар дагагч нь мөн адил зовлон зүдүүрийнхээ төлөө шагнагдах болно.

Есүсийн баривчилгаа, шүүх болон үхлийн үйл явдлуудыг өгүүлсний эцэст Лук 24:1-53 дээр Есүсийн амилал ба тэнгэр өөд одсон талаарх түүхээр Лук Сайнмэдээгээ төгсгөсөн байдаг.

## Амилал ба Тэнгэрт Одсон нь

Лук 24:1-12 дээр Есүсийн булш хоосон байсан тухай болоод тэнгэрэлчийн мэдээ мөн дагалдагч нарынх нь гайхширал ба үл итгэлийн тухай тэмдэглэжээ. Есүс урьдчилж хэлсэн ёсоороо үхэгсдээс амилсан. Тэр Өөрийнхөө төлөө болон Түүнд



итгэдэг бүх хүмүүсийн төлөө үхлийг ялсан.

Лук 24:13-35 дээр Есүс тэр өдрийнхөө орой Еммау хүрэх замд хоёр дагалдагчтай ярилцсан тухай түүх бий. Тэрээр Өөрийн үйлчлэл болон амиллынх нь гэрэлд Хуучин Гэрээг уншихыг тэдэнд сургасан. Библид тэмдэглэсэн бүх зүйл Есүс болон Түүний авралын ажлыг зааж байдаг.


Дараа нь Лук 24:36-49 дээр Есүс дагалдагч нартаа үзэгдэж, эдгээр үйл явдлыг гэрчлэхийг уриалсан. Тэрээр тэдэнд гэмшил ба уучлалын сайнмэдээг бүх үндэстэнд тунхаглах гэсэн Түүний илгээлтийг үргэлжлүүлэхийг тушаасан. Дараа нь Тэрээр дагалдагч нарыг энэ даалгавраа гүйцэлдүүлэхэд нь хүчирхэгжүүлэх Ариун Сүнсийг илгээнэ хэмээн амлсан. Ингэснээрээ Лук өөрийн хоёр дахь ном болох Үйлс номоо танилцуулах суурийг тавьсан харагддаг.

Лук Сайнмэдээгээ 24:50-53 дээрх Есүсийн тэнгэр өөд одсон түүхээр дуусгасан. Энэхүү гайхамшигт үйл явдлыг хараад дагалдагч нар нь Бурханыг хүндэтгэж, баясан, магтав. Лук 2:10-р эшлэлд тэнгэрэлчийн зарласан үлэмж их баяр хөөрийн мэдээ эцэст нь Бурханы ард түмэнд биллээ оллоо. Амилсан, ялагч Эзэн Есүс бол тэдний Аврагч билээ.

Лук Есүсийг дагах нь зөв сонголт байсан гэдгийг харь үндэстэн итгэгчдэд батлахын тулд бичжээ. Есүсийн амьдралын бүхий л тал нь Өөрийн хаанчлалыг байгуулах Бурханы төлөвлөгөөний хэсэг байсан гэдгийг Лук сайнмэдээнийхээ бүтэц, агуулгаараа дамжуулан харуулсан. Тэр бол Исаиагийн авралын эш үзүүлэгийг биелүүлэхээр ирсэн Бурханы хүү, Давидын хүү байв. Есүс бол бүх үндэстнийг өөрийн удирдлага дор авчрах нигүүлсэл, өршөөлийн зогсошгүй хүч байсан. Тэр үнэхээр Бурханы хаанчлалыг эхлүүлсэн. Тэр үнэхээр хүн төрөлхтний бүх гэр бүлд авралыг санал болгож байна. Тэгээд Тэрээр үнэхээр Өөрт нь үнэнч байсан бүх хүмүүсийг аврах болно.

Лукийн Сайнмэдээний нөхцөл байдал, бүтэц ба агуулгыг авч үзсэн учраас одоо бид сүүлчийн гол сэдвээ үзэхэд бэлэн боллоо. Хичээлийн энэ хэсэгт бид Лукийн онцолсон зарим гол сэдвүүдийг судлах болно.

## ГОЛ СЭДВҮҮД



Синоптик Сайнмэдээ нь бүгд Есүс бол Бурханы хаанчлалыг авчрах Христ мөн гэсэн нэг ижил гол сэдэвтэй гэж хэлж болно.

Ерөнхийдөө Матай, Марк, Лук гэсэн гурван Синоптик Сайнмэдээ нь бүгд Есүс бол Бурханы хаанчлалыг авчрах Христ мөн гэсэн нэг ижил гол сэдэвтэй гэж хэлж болно. Гэхдээ эдгээр Сайнмэдээ тус бүр энэхүү гол ойлголтыг янз бүрийн аргаар авч үздэг. Тиймээс бид Лукийн энэ санааг судлахдаа Бурханы хаанчлалыг аврал хэмээн үзсэн Түүний тайлбарт анхаарлаа хандуулах болно.

Лук аврах, аврал, аврагдах, аврагч гэсэн үгсийг бусад Сайнмэдээний бичээчдээс илүү олон удаа буюу багадаа 25 удаа ашигласан. Тэрээр Христгүйгээр бидэнд найдвар үгүй гэдгийг, бидэнд аврал үнэхээр хэрэгтэй гэдгийг онцолсон. Мөн Тэрээр Бурханы хаанчлал бол бидний хамгийн агуу аврал юм хэмээн заажээ.

Аврал гэдэг нэр томьёо нь Хуучин Гэрээний Мессиагийн талаарх найдварт гүн үндэслэсэн байдаг. Бид үүнийг бузар муугийн дарангуйллаас, мөн гэмийн улмаас бууж буй Бурханы шийтгэлээс аврагдах гэж тодорхойлж болно. Хуучин Гэрээний туршид, ялангуяа эш үзүүлэлийн номуудад Бурхан Мессиа нь эцэстээ гэм нүглийн үр дагавраас, тэр байтугай Өөрийнх нь оршихуйгаас аврах аврал болно гэдгийг хүмүүст заасан.

Лук авралыг ийнхүү онцлон үзсэн тул бид сайнмэдээнийх нь гол сэдвүүдийн талаар ярилцахдаа Христийн авралын ажлын өөр өөр талуудтай холбоотойгоор гурван хэсэгт хуваан үзэх болно. Эхлээд бид хувь хүний авралын талаарх Лукийн тодорхойлолтыг авч үзнэ. Хоёрдугаарт, бид тэрээр Бурхан бол бидний Аврагч гэж дүрсэлсэн болохыг харна. Гуравдугаарт, бид ямар төрлийн хүмүүс аврагдаж байсан талаар судлах болно. Ингээд эхлээд Лук авралыг хэрхэн тодорхойлж байснаас эхэлцгээе.

## АВРАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Лук Сайнмэдээнийхээ туршид хувь хүний аврал нь юуны түрүүнд хүмүүсийн нөхцөл байдлыг бүрэн өөрчилж буй явдал гэдгийг харуулсан. Энэ нь тэднийг өөрчилж, Бурханы өмнө зогсох боломжийг өгч, хувь тавиланг нь эргүүлдэг. Ийнхүү тэд хараалын оронд ерөөлийг хүлээн авдаг.

Бид бүгд гэмтэн болж төрсөн. Үүний дүнд бид Бурханаар яллагдаж, мөнхийн сүйрэл рүү явах тавилантай байв. Гэвч Сайнмэдээ бидэнд нүглийн уучлалыг өгсөн бөгөөд ингэснээр Бурханд биднийг яллах шалтгаан үгүй болсон. Лук бээр авралын үр дүнд Бурхан болон бидний хооронд амар амгалан тогтсон гэдгийг олонтоо дурдсан байдаг. Одоо бид Бурханы тааллыг олсон шинэ байр суурьтай болсон. Тиймээс бид Есүс эргэн ирж, дэлхийг төгс болгох үед бидэнд өвлөгдөх Бурханы хаанчлал дахь мөнхийн ерөөлүүдийг хүлээн авдаг. Тэрхүү шинэ дэлхийд өвчин, зовлон, үхэл, өвдөлт, дутал гачил гэж байхгүй байна. Бидний амьдрал яг одоо ямар ч байсан бид ирэх ертөнцөд элбэг дэлбэг, эрх дархтай байх аж.

**Лукийн Сайнмэдээг уншигчид Есүс нөлөө багатай бүлэг болох эмэгтэйчүүд, харь үндэстнүүд, хүүхдүүд зэрэгт онцгой анхаарал хандуулдаг байсныг онцолдог. Ялангуяа энэ нь Есүсийн амьдрал, үйлчлэлийн нийгэм дэх хүрээ нь байсан юм. Миний бодлоор үүнд гүн гүнзгий теологийн учир шалтгаан байгаа. Энэ нь хүч чадалгүй**

хүмүүст давуу байдлыг өгдөг Бурханы эцсийн үед хэрхэн засаглах вэ гэдгийг Лук ойлгож байсантай холбоотой. Үүний дүнд хүчирхэг хүмүүст эсрэгээрээ давуу байдлыг өгөхгүй байгаа дүр зургийг харж болдог. Мэдээж хэрэг "тэнгэрийн хаанчлал ойрхон байна" гэж тунхаглахдаа эдгээр хүмүүсийн нийгмийн байр суурийг ийнхүү сольж байгаа нь Сайнмэдээний номууд болон Шинэ Гэрээ, цаашглаад төгсгөл цагийн буюу эсхатологийн хувьд тийм ч ховор ойлголт биш л дээ. Та үүнийг Библийн илчлэл бүрээс олж харна. Эхлэл номд мэдээж удаах хөвгүүд нь үргэлжид ууган хөвгүүдийн өмнө сонгогддог байсныг бид олонтоо хардаг. Энэ нь хүлээлтийг орвонгоор нь эргүүлж орхидог шүү дээ. Энэ бол Хуучин гэрээн дэх хүлээлтийг орвонгоор нь эргүүлсэн зөвхөн нэг л жишээ юм. Харин Лукийн хувьд Шинэ Гэрээнд буй ийнхүү хүлээлтийг орвонгоор нь эргүүлж орхисон хамгийн оргил биеллийг авч үзсэн харагддаг. Тодруулбал түрүүн дурдсан хүчтэй болон хүчгүй хүмүүсийн байр суурийг орвонгоор нь эргүүлж буйг онцолсон байна.

— Др. Дэвид Р. Бауэр

Лук 7-р бүлэгт Баптисч Иохан Есүсийг үнэхээр Мессиа мөн эсэхийг асуухаар элч илгээж байсныг та санаж байгаа байх. Тэгэхэд нь Есүс Өөрийн олон нийтийн үйлчлэлийг эхлүүлэх үедээ синагогт уншиж байсан Исаиа 61:1-2-р эшлэлийг өөрийн үгээр дүгнэж хариулсан. Лук 7:22-т буй Есүсийн хариултыг дахин сонсоцгооё. Тэрээр энд:

“Хараагүй нь хараа орж, суунги нь алхаж, уямантай нь цэвэршиж, сонсголгүй нь сонсож, үхэгсэд нь амилж, ядууст сайнмэдээ тунхаглагдаж байна” гэжээ (Лук 7:22).

Есүсийн энд дурдсан бүхэн авралын нэг хэлбэр буюу муу нөхцөл байдлыг сайн болгож орвонгоор нь эргүүлж буйг харж явдал юм.

Шинэ дэлхийд эдгээр муу нөхцөл байдлууд бүрмөсөн үгүй болно. Одоо ч гэсэн аврал нь эдгээр мөнхийн ерөөлүүдийг бидэнд урьдчилан амсуулж байдаг. Гэвч авралын энэхүү орвонгоор нь эргүүлдэг агуу байдал нь бидний гадаад нөхцөл байдлыг өөрчлөх төдийгөөр хязгаарлагдахгүй. Тэдгээр нь мөн биднийг дотроос нь өөрчилдөг. Есүс Лук 6:27-36 дээр хэлэхдээ:

“Дайснуудаа хайрла, та нарыг үзэн ядагчдад сайныг үйлд. Та нарыг хараагсдыг ерөө, та нарыг доромжлогсдын төлөө залбир... Та нар дайснуудаа хайрла, сайныг үйлд, хариу харалгүйгээр зээлдүүл. Тэгвэл шагнал чинь агуу болоод та нар Хамгийн Дээд Нэгэний хөвгүүд байх болно. Учир нь Тэр Өөрөө үл талархагсдад болон ёрын муу хүмүүст ч аятайхан ханддаг юм. Эцэг чинь өршөөнгүй байдаг шиг өршөөнгүй бай” гэжээ (Лук 6:27-36).

Хаанчлалын ерөөлүүд нь зөвхөн гадаад нөхцөл байдлыг эргүүлээд зогсдоггүй. Тэд мөн аврагдсан хүмүүсийн зан чанар болон үзэл харааг нь ч өөрчилдөг. Гаднах нөхцөлийг эргүүлэн өөрчилдөгтэй нэгэн адил эдгээр дотоод өөрчлөлтүүд нь одоогийн энэ ертөнцөд хэсэгчлэн, харин дараагийн ертөнцөд бүрэн илэрдэг. Яг одоо Ариун Сүнс бидний дотор нутаглаж байгаа учраас ертөнцийг шинэ нүдээр харж, бас өөрөөр сэтгэж, үйлдэж эхэлдэг. Эдгээр өөрчлөлтүүд тэнгэрт үргэлжлэх бөгөөд бид гэмийн оршихуй, ялзрал ба үр дагавраас нь бүрэн ангижрах болно. Мөн Есүс эргэн ирж, шинэ дэлхий дээр шинэ биеийг бидэнд өгөх үед эдгээр нь бүрэн дүүрэн болно.

Авралын эдгээр ерөөлүүд нь Лук яагаад Сайнмэдээндээ ямагт баяр баясгаланг авралын зөв зүйтэй хариу үйлдэл юм хэмээснийг тайлбарлаад өгдөг. Үүнийг бид Лук 1:68-79 дээрх Зехариагийн дуу, Лук 1:46-55 дээрх Мариагийн дуу, Лук 2:29-32 дээрх Симеоны дуу гэх мэт олон дуунуудыг Лук оруулсан байгаагаас харж болдог. Авралын баяр баясгалангийн тухай бид мөн Лук 1:14 дээрх Зехариад хэлсэн тэнгэрэлчийн тунхаглалаас харж болно. Түүнчлэн энэ нь Лук 2:10-11 дээрх хоньчдод хүргэсэн агуу баяр хөөрийн сайн мэдээнд ч бий. Мөн баяр хөөрийн сэдэв нь Лук 15-р бүлэгт гардаг төөрсөн хонь, алдагдсан зоос, алдагдсан хүүгийн тухай Есүсийн сургаалт зүйрлэлүүдийн гол сэдэв мөн. Есүс Лук 6:21-23 дээр баяр хөөрөөр дүүрэхийг дүгнэн хэлсэн байдаг. Энд:

“Эдүгээ гашуудан уйлж буй хүмүүс ерөөлтэй еэ! Та нар инээх болно...  
Тэр өдөр баярла, баясан цовхч” гэжээ (Лук 6:21-23).

Бурхан бидэнд баяр баясгалан өгөх авралыг санаачилсан билээ. Бидний гэм нүгэл арчигдан, бид Түүнтэй эвлэрсэн харилцаатай болж, Түүний хаанчлалын ерөөлүүдийг өвлөн авч байгаа учраас Тэр биднийг баяр хөөртэй байгаасай гэж хүсдэг. Энэ сэдэв Лукийн хувьд маш чухал байсан тул тэрээр Сайнмэдээгээ ч үүгээр дуусгасан байдаг. Есүсийг тэнгэр өөд одсоны дараа дагалдагч нар нь юу хийснийг Лук 24:52-53 эшлэлд өгүүлдэг. Энд:

“Тэд ... үлэмж баяр хөөртэйгөөр Йерусалимд буцан ирж. Сүмд байнга байж, Бурханыг магтсаар байв” хэмээжээ (Лук 24:52-53).

Бид Бурхан хэн болохыг нь таньж, Эзэн бол сайн гэдгийг амталж мэдэх үед энэ нь биднийг баяр хөөр, бахдам жаргалд хөтөлдөг. Хэрэв би эхнэртээ цэцэг авчирч өгөөд "Хонгор минь, май энэ цэцэг байна, би чамд ингэж өгөхөөс өөр аргагүй шүү дээ" гэж дурамжхан хэлбэл энэ нь түүнд таалагдахгүй. Би эхнэрээ хайрладаг учраас үүнийгээ баяр хөөр, бахдам жаргалтайгаар хийх хэрэгтэй шүү дээ. Тиймээс Бурхан хэн бэ гэдгийг таньж мэдсэний анхдагч илэрхийлэл нь Түүн доторх баяр хөөр юм аа. Тиймээс Бурханы дотор баярлах, Бурханы дотор бахдан жаргах, Түүнд сэтгэл хангалуун байх мэдрэмж нь Христитгэгчдийн амьдралын гол цөм

МӨН.

— Др. К.Эрик Тоеннес

Авралыг хэрхэн тодорхойлсныг санаж байгаарай. Харин одоо хоёр дахь гол сэдэв болох Лук Бурханыг бидний Аврагч хэмээн онцолсон талаар үзэцгээе.

## БУРХАН БОЛ АВРАГЧ

Бид Бурхан бол Аврагч гэдгийг гурван алхмаар авч үзэх болно. Өөрөөр хэлбэл Аврал нь Бурханы хүчээр, Бурханы төлөвлөгөөний дагуу, Бурханы Хүүгээр дамжин ирдэг гэдгийг бид харах болно. Аврал Бурханы хүчээр ирдэг гэдгийг эхлээд харцгаая.

## Бурханы Хүч

Лукийн Сайнмэдээ нь Бурхан бол ард түмнийхээ Аврагч гэсэн Хуучин Гэрээний санааг байнга давтан цуурайтуулдаг. Жишээлбэл, энэ нь Лукийн эхний бүлгүүдийн ноёлох сэдэв бөгөөд бүхэл бүтэн номын өнгө аясыг тодорхойлдог. Лук 1:47 дээр Бурхан түүний Аврагч байсан тул Мариа баярласан гэжээ. Лук 1:68-79 дээр Бурханы авчирч буй авралын тухай Зехариа дуулсан тухай бий. Лук 2:29-30 дээр Симеон нялх Есүсийг тэврэх үедээ юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:

“Эзэнтэн, Та Үгийнхээ дагуу зарц намайгаа амар тайван явуултугай.  
Учир нь Миний нүд минь Таны авралыг харлаа” гэжээ (Лук 2:29-30).

Симеон Бурханыг Эзэнтэн буюу Грекээр *despota* гэж нэрлэсэн. Энэ нь Бурханд бүх бүтээлийг захирах хүч, эрх мэдлийг хамруулсан үг юм. Мөн Симеон "Таны аврал" гэснээрээ Бурхан авралыг авчрахын тулд хүчээ ашиглаж байгааг нь заажээ.



Мариа

Зехариа

Симеон

Мөн энэ сэдэв Лукийн Сайнмэдээний үлдсэн хэсэгт ч үргэлжилдэг. Жишээлбэл, Баптисч Иохан Бурханы авралыг бүх дэлхийг шинэчлэх хүч чадалтай нь холбон тунхагласан байдаг. Лук 18:26-27 дээр Есүс хүмүүс авралд хүрэх нь боломжгүй, харин Бурханд бүх зүйл боломжтой хэмээн заасан.

Лук уншигчдадаа Бурхан бүхнийг удирдаг захирдаг гэдгийг ойлгуулахыг хүссэн. Тиймээс хүн хүч чадал, оюун ухаан, хичээл зүтгэл эсвэл эд баялгаар авралд хүрч чадахгүй. Аврал нь Бурханд байдаг. Энэ бол Түүний хүчээр л гүйцэлддэг, Түүний үйл хэрэг юм. Зөвхөн Бурхан л хүмүүсийг Өөрийн шүүлтээс чөлөөлөх эрх мэдэлтэй. Зөвхөн Бурхан л хүмүүсийг дотроос нь өөрчлөх хүч чадалтай. Зөвхөн Бурхан л Өөрийн хаанчлалыг дэлхий дээр авчирч чадах хүч чадалтай. Зөвхөн Бурхан л ард түмнээ уг хаанчлалын ерөөлүүдээр шагнах чадвартай.

Лук Аврал нь Бурханы хүч чадлын үр дүнд бий болдог гэдгийг онцлохын зэрэгцээ аврал бол Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг гэдгийг заасан.

## Бурханы Төлөвлөгөө

Жишээлбэл, Лук 4-р бүлэгт Есүс олон нийтийн үйлчлэлээ эхлүүлэх үедээ Исаиа 61:1-2 эшлэлүүдийг уншсан. Тэгээд Тэр эш үзүүлэгийг яг тэр цагт, тэр газар биеллээ оллоо хэмээн олныг гайхшируулсан. Лук Сайнмэдээнийхээ үлдсэн хэсэгт Есүсийн амьдралын гайхалтай үйл явдлууд нь Хуучин Гэрээн дэх Бурханы амлалтуудыг биелүүлсэн гэдгийг харуулсан. Үүгээрээ аврал бол Бурханы төлөвлөгөө гэдгийг үргэлжлүүлэн илэрхийлсэн юм. Лук 24:44 дээр Есүс нийтэд хандсан үйлчлэлээ төгсгөх үедээ хэлсэн үгийг сонсоцгооё. Энд:

“Миний ярьж байсан ёсоор Мосегийн Хууль, Эш үзүүлэгчид болоод Дуулал дахь Миний тухай бичигдсэн бүхэн биелэгдэх ёстой” гэжээ (Лук 24:44).

Хуучин Гэрээ бүхэлдээ Бурханы Есүсээр дамжуулан гүйцэлдүүлж буй авралын тухай өгүүлдэг. Өөрийн хүмүүсийг ийм байдлаар аврах нь үргэлж л Бурханы төлөвлөгөө байсаар ирсэн.

Аврал нь Бурханы төлөвлөгөөг биелүүлдэг гэдгийг Лук мөн өөр байдлаар харуулсан байдаг. Энэ нь Есүсийн хийсэн зүйлс нь зайлшгүй чухал байсан бөгөөд эдгээр нь Бурханы хүсэж, урьдаас тогтоосон зүйлс гэдгийг үргэлж заадаг. Зөвхөн нэг жишээ болгон Лук 9:22 дээр Есүс Өөрийнхөө зовлон ба үхлийг хэрхэн дүрсэлснийг сонсоцгооё. Энд:

“Хүний Хүү олон зовлон эдэлж, ахлагчид, ахлах тахилч нар болон хуулийн багш нарт ад үзэгдэж, алуулах ба гурав дахь хоног дээрээ амилна гэв” гэсэн байна (Лук 9:22).

Есүс юу болох талаар тайлбарлахдаа "ёстой" гэсэн утгатай грек хэлний *дэй* гэдэг



үгийг хэрэглэсэн. Энэ нь өөрөөр хэлбэл "зайлшгүй шаардлагатай" гэсэн утгатай байна. Яагаад зайлшгүй шаардлагатай байсан бэ? Учир нь Бурхан үүнийг хүссэн юм. Есүст тохиолдсон бүх зүйл ард түмнээ аврах Бурханы өнө эртний төлөвлөгөөний нэг хэсэг байсан.

Бурхан бол бидний Аврагч гэдгийг харуулах гурав дахь зүйл бол аврал нь Бурханы Хүү Есүс Христээр ирдэг явдал юм.

## Бурханы Хүү

Лукийн Сайнмэдээнд Есүсийг Бурханы Хүү гэдгийг дахин дахин нотолсон байдаг. Лук 1:32-35 дээр Түүний төрсөн тухай тэнгэрэлч нар тунхагласан шиг заримдаа Есүс бол Бурханы Хүү гэдгийг Бурхан хүн болж биежсэн гэж тодорхойлдог. Бусад үед энэ нь Түүний эрх мэдлийг онцолж өгдөг. Үүнийг бид Лук 3:22 дээр баптисм хүртэх үед нь Бурхан тэнгэрээс таалан ярих үед, мөн Лук 9:35 дээр Түүнийг хувирч өөрчлөгдөх үед Бурхан Өөрийн Хүүг сонсохыг хүмүүст зааварласан зэргээс бид харна. Бусад үед энэ нь Сүүлчийн зоогийн үеэрх шиг Түүнийг Бурханы харьяат Мессиа хаан хэмээн тодорхойлсныг бид Лук 22:29 дээрээс харж болно.

Гэхдээ Есүсийг Бурханы Хүү хэмээн дурдсан эдгээр бүх эшлэлүүдэд дор хаяж нэг нийтлэг зүйл байдаг. Тэд бүгдээрээ Бурхан Есүсээр дамжуулан авралыг гүйцэлдүүлж буй гэдгийг харуулдаг. Есүс бол ард түмнээ буруутгалаас аврахын тулд Тэдний оронд үхэж, Бурханы хаанчлалыг дэлхий дээр авчрахын тулд дэлхийд илгээгдсэн Бурханы Хүү юм.

Заримдаа Христитгэгчид Эцэг бол биднийг үзэн яддаг ууртай Бурхан, Есүс бол биднийг өмгөөлөн зогсохоор ирсэн Түүний тэрслэгч Хүү хэмээн буруу боддог. Харин үнэнээс цааш үнэн гэж үгүй. Эцэг нь Түүнийг илгээсэн учраас л Есүс биднийг аврахаар ирсэн. Тийм ээ, Есүс үнэхээр бидний Аврагч. Мөн Тэрээр үнэхээр биднийг Эцгийн шийтгэлээс авардаг. Гэхдээ Түүний авчирдаг аврал нь Эцгээс эхтэй гэдгийг ойлгох нь маш чухал юм. Бурханы Хүүгийн хувьд Есүс зөвхөн Эцгийн тушаасан зүйлийг л хийдэг. Тэрээр Бурханы төлөвлөгөөг биелүүлэхийн тулд Бурханы хүчийг ашигладаг. Ийнхүү Есүсийн авралын үйл хэрэг нь Бурхан Эцэг бол бидний туйлын Аврагч гэдгийг нотолж байна.

Ингээд бид Лук авралыг хэрхэн тодорхойлсон, мөн Бурхан бол бидний Аврагч мөн болох талаар харлаа. Тэгэхээр одоо номынхоо гурав дахь гол сэдэв болох ямар төрлийн хүмүүс аврагдаж байсан талаар үзэцгээе.

## АВРАГДСАН ХҮМҮҮС

Хэрэв Есүс тухайн үедээ нийгэмд нэр хүндтэй, эрх мэдэлтэй хүмүүст авралыг санал болгосон бол хэн ч гайхахгүй байх байсан. Бурханы хууль бүрийг чанд мөрддөг хүмүүсийг яагаад аварсан юм бол гэж хэн ч гайхахгүй байсан биз. Мөн хэрэв Тэрээр Иудейн нийгэмд хэдийнээ жигшигдсэн хүмүүсийг, зарим нь өөрөө

алдаа гаргаснаас болж Бурханы ерөөлийг алдсан хүмүүсийг буруутган ялласан бол хэн ч гайхахгүй байх байлаа. Гэвч эдгээр нь Есүсийн хийсэн зүйл биш юм. Лукийн Сайнмэдээний гол сэдвүүдийн нэг нь Есүс ямар хүмүүсийг аварч, тэдэнд ямар гайхалттай хүндэтгэл, байр суурийг өгсөн бэ гэдэгт анхаардаг. Энэ нь хүмүүсийг гайхшируулж орхидог.

Лукийн хүүрнэлийн нэг анхаарал татахуйц зүйл бол Тэрээр хамгийн өчүүхэн, адгийн, алдагдсан нөхдөд анхаардаг явдал юм. Үнэндээ түүний гол сэдвүүдийн нэг нь нөхцөл байдлыг орвонгоор нь эргүүлэх явдал байдаг. Хамгийн өчүүхэн, адгийн, алдагдсан нь Бурханы хаанчлалыг өвлөж, хамгийн эхэнд, хамгийн агуу нь болох аж. Лук Сайнмэдээн дэх ёс зүйн талыг үнэхээр онцлон харуулсан байдаг. Тэрээр Есүсийн үйлчлэлээс юу нь сайшаалтай, ёс суртахуунтай гэж ялгарч харагдаж байгааг анхаарч үзсэн. Тиймээс хоёр цуврал ном болох "Лук" болон "Үйлс" номын аль аль нь ядуус ба эмэгтэйчүүд, өвчтэй ба өтгөст анхаарал хандуулсан байдаг. Лук болон Үйлс номд бусад Сайнмэдээнүүдээс илүүтэйгээр эдгээр зүйлсийн талаар онцлон тэмдэглэсэнд гайхах зүйлгүй. Хэрэв бид Есүсийн ерөөлтэй еэ сургаалын тухайд Матай "Сүнсэндээ ядуус ерөөлтэй еэ" гэсэн бол Лук зүгээр л "Ядуус ерөөлтэй еэ" гэсэн байдаг. Энэ бол Лукийн жинхэнэ анхаарч үзсэн асуудал юм. Зөвхөн Есүсээр дамжуулан золилт ирээд зогсохгүй бас шударга ёс ч ирдэг гэж итгэдэг учраас тэрээр энэ асуудалд анхаарал хандуулсан байна. Нийгмийн алдаа зөрчил, хүн төрөлхтний уналтыг засаж залруулах ажлыг Есүс эхлүүлсэн. Тиймээс Есүс бол энэ дэлхийн Аврагч гэдгийг онцлон тэмдэглэхийг Лук үнэхээр хүссэн. Бодоод үзээрэй, Тэр бол хүн бүрийн Аврагч мөн. Есүс дотор бүхий л хэрэгцээ маань хангагддаг. Та хамгийн дээд зиндааны элит хүмүүсийн нэг ч бай, сайн боловсролтой хүн ч бай, эсвэл нийгмийн хамгийн алдартай хүн ч бай, эсвэл бүр хамгийн дордын дорд нь ч бай Есүс бол хүн бүрийн төлөө байдаг. Лук үүнийг л гарцаагүй онцлон тэмдэглэхийг хүссэн.

— Др. Бен Уитерингтон III

Энэ хичээлийнхээ зорилгын хүрээнд бид Лукийн байнга анхаарал хандуулдаг байсан гайхширал төрүүлэм дөрвөн төрлийн хүмүүсийг л үзнэ. Ингээд Харь үндэстнээс нь эхэлье.

Хуучин Гэрээ харь үндэстнүүд эцэстээ Бурханы хаанчлалд орж Түүний аврал, ерөөлүүдийг хүлээн авах тухай өгүүлдэг. Гэвч Израилын өдрүүдэд иудейчүүд ихэвчлэн харь үндэстнүүдийг Бурханы хаанчлалын ерөөлөөс таслагдсан гэж дорд үздэг байв.

Лук Сайнмэдээгээ бичих үед дэлхий даяарх Христийн чуулган ихэвчлэн харь

үндэстний итгэгчдээс бүрдсэн байв. Түүхийн туршид Бурхан харь үндэстнүүдийг гайхалтай арга замаар ерөөх санаагаа тодорхой илэрхийлсэн. Мөн бид энэ хичээлийн эхэнд харсанчлан Лукийн бичих болсон нэг шалтгаан нь харь үндэстнүүд Христитгэгч болох нь алдаа биш гэдгийг батлах явдал байв. Тиймээс тэрээр Сайнмэдээнийхээ туршид Хуучин Гэрээний итгэл найдвар, үзэл санааг биелүүлэхийн тулд аврал харь үндэстнүүдэд хүрч байсан газруудад анхаарлаа хандуулсан байдаг.

Жишээлбэл, Лук 2:10-14 дээр тэнгэрэлч нар Сайнмэдээний баяр баясгалан нь “бүх хүмүүст” болон “дэлхийн бүх хүмүүст” байх болно хэмээн тунхагласан. Тэнгэрэлч нар Израилын шинэ хааныг Иудейн ард түмнийг аврахын тулд төрсөн гэж хэлэхийн оронд илүү даяар шинжтэй хэллэгээр ярьсан. Лук 2:32 дээр Симеон нялх Есүсийг "харийнханд илчлэлийн гэрэл" болно гэж тунхагласан. Бүх дөрвөн Сайнмэдээний номонд Баптисч Иоханы түүхэнд Исаиа 40-р бүлгийг эш татсан байхад зөвхөн Лук 3:6 дээр "Махбодтой бүхэн Бурханы авралыг үзнэ" хэмээн дэлгэрүүлсэн байдаг.

Иудейчүүдийн дайснаа гэж үздэг Самаричууд ч мөн аврагдах боломжтой гэдгийг Лук тэмдэглэжээ. Жишээлбэл, Лук 17:11-19 дээр Есүс уяман өвчтэй хүнийг арван хүнийг эдгээсэн боловч буцан ирж Түүнд талархсан нэгэн нь Самари хүн л байжээ. Зөвхөн Лук л Сайн Самари хүний талаарх сургаалт зүйрлэлийг бичсэн байдаг. Самари хүн хөршөө хайрлах хайрын үлгэр жишээ болсон тухай Лук 10:30-37-д өгүүлдэг.

Үүнээс гадна Лук харь үндэстнүүд л Есүсийг Аврагч гэдэгт итгэсэн жинхэнэ итгэлээ харуулсныг тэмдэглэжээ. Жишээлбэл, Лук 7:9-р эшлэлд Есүс Ромын зуутын даргын тухай ийнхүү өгүүлэв. Тэр энд:

“Ийм агуу итгэлийг Би Израилд хүртэл олоогүй юм” гэжээ (Лук 7:9).

Мөн бид энэ хичээлийн эхэнд үзсэнчлэн Лук Есүсийн угийн бичгийг Адам хүртэл ухраан жагсаасан. Үүгээрээ Есүс Адамын бүх удам угсаа, тэр дундаа Иудейчүүд болон харь үндэстнүүдийг аль алиныг нь аврахаар ирсэн гэсэн санааг харуулсан юм.

Лукийн Сайнмэдээнд авралыг хүлээн авч гайхашруулсан хоёр дахь хүмүүс бол гэм нүгэлтнүүд байлаа. Өнөөдөр үнэндээ бүх хүн төрөлхтөн нүгэлтэй гэдгийг ойлгох нь чухал юм. Гэвч Есүсийн үед зарим хүмүүсийн гэм нүгэл нь аймшигтай их бөгөөд нийтэд ил байлаа. Жишээлбэл, Лук 7:36-50 дээрх ёс суртахуунгүй эмэгтэй болон Лук 19:1-9 дээр буй татвар хураагч Закхай нар шиг хүмүүс Иудейн нийгэмд гадуурхагддаг байв. Татвар хураагчид элэг нэгтнүүдээ засгаас шаарддаггүй хэт өндөр татвар ногдуулж амьдралаа залгуулдаг байсан тул гэмтнүүд байсан. Гэвч Есүс тэднийг хүртэл аврахаар ирсэн. Тэрээр итгэлээр гэмшсэн хэн бүхэнд аврал өгөхийг хүсдэг байв. Зөвхөн нэг жишээ болгон Лук 5:29-32 дээрх түүхийг сонсоцгооё. Энд:

“Есүст зориулж Леви гэртээ том цайллага хийв. Тэнд татвар хураагчид олноороо бас өөр олон хүний хамт тэдэнтэй ширээнд тухлан сууж байжээ. Фарисайчууд, тэдний хуулийн багш нар Түүний шавь нарт

дургүйцэн —Та нар чинь яагаад татвар хураагч нар ба нүгэлтнүүдийн хамт идэж ууж байдаг билээ? гэхэд Есүс тэдэнд —Эмч эрүүлд нь бус, өвчтэйд нь хэрэгтэй. Би зөвтийг бус, харин нүгэлтнүүдийг гэмшилд дуудахаар ирсэн юм” гэв (Лук 5:29-32).

Лукийн Сайнмэдээнд аврагдаж гайхшируулсан гурав дахь төрлийн хүмүүс бол эмэгтэйчүүд байлаа. Есүсийн амьдарч байсан эртний Газар дундын тэнгисийн дорнын ертөнцөд эмэгтэйчүүд нийгэмд тийм ч их эрх мэдэл байр суурь эзэлдэггүй байсан бөгөөд тэднийг үнэлдэггүй байв. Гэвч Лук Есүс тэдэнд хэрхэн аврал авчирсанд анхаарлаа хандуулсан. Лук 8:41-53 дээр Есүс Иаирын охин болон арван хоёр жилийн турш цус алдаж байсан эмэгтэйг эдгээжээ. Эртний эцгийн эрхт ёстой нийгэмд ямар ч тусламж, найдваргүй байдаг бэлэвсэн эмэгтэйчүүдэд Есүс их өршөөл, энэрлээ үзүүлсэн. Лук 7:11-17 ба 18:1-8 зэрэг эшлэлүүдэд Есүс эдгээр хамгийн их тусламж хэрэгтэй байгаа хүмүүст санаа тавьж, халамжилдаг байсныг дүрсэлсэн.

Лукийн эмэгтэйчүүдийн авралыг онцолсон хамгийн гайхалтай арга хэлбэрийн нэг нь дорд эмэгтэйчүүдийг бардам шашны удирдагчидтай харьцуулсан явдал байлаа. Тухайлбал, Лук 13:14-15 дээр Есүс синагогийн захирагчийг хоёр нүүрт гэж нэрлэсэн бол дараагийнх нь эшлэлд тахир дутуу эмэгтэйг "Абрахамын охин" хэмээн дуудсан байдаг. Бид Лук 7:37-50 дээрээс үүнтэй төстэй харьцуулалтыг олж хардаг. Энд Есүс бардам фарисай Симоныг буруутгаж, нүгэлт эмэгтэйг уучлан хүлээн авсан байдаг.

Бурханыг хайрлана гэдэг нь юу гэсэн үг вэ гэдгийг харуулахын тулд Лук Есүсийн найз Мариагийн түүхийг ярьжээ. Лук 10:27 дээр хоёр агуу зарлиг бол Бурханыг болон хөршөө хайрлах явдал юм гэж Есүс заасан. Дараа нь 38-42-р эшлэлд Мариа онцгойлон Түүний сургаалыг дуулгавартай сонссоноороо Бурханыг хэрхэн хайрлахыг үлгэрлэн харуулсан. Петр биш, Иохан нь ч биш, бүр Иудейн удирдагч ч биш, харин эмэгтэй хүн бурханлаг сүсэгт байдлын үлгэр жишээ болжээ.

Эцэст нь Лукийн Сайнмэдээнд аврагдсан хэмээн хүмүүсийг гайхашруулсан дөрөв дэх төрлийн хүмүүс бол ядуус юм. Мариа, Иосеф хоёрын гэр бүл ядуу байсныг дурдсанаар Лук Сайнмэдээгээ эхлүүлсэн. Бид үүнийг Лук 2:24 дээр тэдний сүмд авчирсан өргөл нь Левит 12:8-д заасан ядуусын өргөл байснаас мэдэж болно.

Лук 12:13-21 дээрх мунхаг баяны сургаалт зүйрлэл, Лук 16:19-31 дээрх баян эр ба Лазар хоёрын түүх зэргээс Есүс ядуусыг таалан хүлээн авдаг байсныг Лук мөн харуулсан. Исаиа 61:1 эшлэлээс Есүсийн уншсан хэсгийн хамт харцгаая. Энэ нь Лук 4:18 дээр бий. Энд:

“Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь ядууст сайнмэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм” гэжээ (Лук 4:18).

Лук энэ үйл явдлыг мэдээлсэн цорын ганц Сайнмэдээний бичээч юм. Мөн тэрээр үүнийг Есүсийн бүхий л үйлчлэлийнх нь загвар болгон оруулсан байдаг. Түүний хэлэх гэсэн санаа бол Бурханы хаанчлалыг авчрахын нэг хэсэг нь ядууст авралын Сайнмэдээг тунхаглах явдал гэдэг нь байв. Орчлон ертөнцийн Бурхан нийгмээс

гадуурхагдсан хүмүүсийг хүртэл аврахын тулд хүн болж ирсэн гэдгийг харуулахад Лук онцгой анхаарсан. Харь үндэстнүүд, гэмтнүүд, эмэгтэйчүүд, ядуус нь Иудейн нийгэмд хамгийн бага эрх эдэлдэг байсан тул Бурханы хаанчлалын хамгийн агуу ерөөлүүдийг өвлөн авна гэдгээ төсөөлөө ч үгүй байв. Тэрээр Өөрийг нь Аврагч, Их Эзэн гэж хүлээн авсан бүх хүмүүсийг бүрэн хүлээн авч, мөнх ерөөлүүдийг амласан.

Лук Сайнмэдээний бусад бүх бичээчдээс илүүгээр тухайн үеийн Палестины нийгэмд орхигдсон бүлгүүдэд онцгой ач холбогдол өгсөн байдаг. Бид түүнийг эрчүүдийн тухай өгүүлэх болгондоо эмэгтэйчүүдийн түүхийг хослуулан бичиж байгааг байнга харна. Тэрээр Самаричуудад онцгой анхаарал хандуулж, ядууст ч анхаарч байгааг бид харж байна. Лукийн Сайнмэдээнд л байдаг Лазар болон баян эрийн тухай сургаалт зүйрлэлийг бид харж болдог. Мөн зөвхөн Лук номд л гардаг сургаалт зүйрлэл болох Сайн Самари хүний түүх ч бий. Тиймээс Есүсийн сургаалын талаарх эдгээр түүх нь Назар хот дахь номлолтой нь маш сайн нийцдэг. Энэ нь "Би ирлээ, өнөөдөр Бичвэр биеллээ" гэж хэлдэг бөгөөд ядуус болон олзлогдогсод, дарлагдсан хүмүүст Сайнмэдээг тунхаглахаар Сүнс над дээр байна гэдэг. Мөн Есүс дагалдагч нартаа найр хийх гэж байгаа бол доголлонг хийгээд ядуусыг ч бас урих хэрэгтэй хэмээн өгүүлдэг. Тиймээс бид Бурханы дүр төрхийг тээсэн бусад хүмүүстэй харилцахдаа өөрсдийгөө байх ёстойгоос илүү дээр гэж бодох ёсгүй гэдгийг Есүс энд харуулдаг. Энэ тухай Паул ч мөн өгүүлсэн байдаг. Гэхдээ Есүс нигүүлслээрээ нийгмийн бүхий л талбарт хүрсэн гэдгийг бид харах хэрэгтэй. Тэр дагалдагч нараа ч мөн үүнийг хийлгэхээр тулд дуудсан. Бид ч мөн үүнийг хийх ёстой. Есүсийг биеэ үнэлэгчид болон гэмтнүүдтэй хамт байлаа хэмээн тохуурхах үед Тэрээр "би зөвтийг бус харин нүгэлтнүүдийг гэмшилд дуудахаар ирсэн юм" гэж хариулдаг. Тиймээс энэ нь Бурханы ард түмэн, тэр үеийн нийгмийн бүх талбарт хүрэх гэсэн Есүсийн зорилгыг тусган харуулаад зогсохгүй бид үнэндээ хэн болох, бидний бодит хэрэгцээ юу болохтой ч мөн хамааралтай. Бид бүгдэд хэрэгтэй бүх зүйл бол Бурханы нигүүлсэл мөн. Бид өөрсдийн сайн үйлсээрээ эсвэл нийгэм дэх өөрсдийн байр сууриараа Бурханы тааллыг хүртэж чадахгүй. Тиймээс бид бүгд Бурханы өмнө тэгш эрхтэй бөгөөд бие биедээ нигүүлсэнгүй байж, нэгэнт бидэнд нэг л ижил хэрэгцээ байгаа учраас бие биедээ туслах ёстой юм.

— Др. Грегори Р. Пэрри

---

## ДҮГНЭЛТ

Энэ хичээлээр бид Лукийн Сайнмэдээг бичээч болон анхны хүлээн авагчид нь хэн байсан, мөн бичих болсон үндсэн шалтгааныг авч үзсэн. Ингэхдээ үүний бүтэц, агуулгын талаар харсан. Мөн гол сэдвүүд нь авралын сэдэвтэй холбоотой байдаг гэдгийг судалсан. Хэрэв бид Лукийн Сайнмэдээг уншихдаа эдгээрийг санаж байвал үүний утгыг илүү сайн ойлгож, чуулган болон энэ дэлхийн амьдралдаа хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй байх болно.

Лукийн Сайнмэдээнд Есүсийг хайраар дүүрэн дэлхийн Аврагч болон ирсэн Бурханы сүр жавхлант Хүү хэмээн дүрсэлсэн байдаг. Тэрээр үндэс угсаа, эд хөрөнгө, байр сууринаас нь үл хамааран хүн бүрд Бурханы авралын Сайнмэдээг хүргэдэг. Тухайн үед Лукийн Сайнмэдээ нь харь үндэстний Христитгэгчид нь Иудейн Мессиаг дагаснаараа алдаа гаргаагүй юм гэдгийг баталдаг. Мөн энэ нь бүх цаг үед ч үнэн байна. Нэгдүгээр зуунаас хойш чуулганы дийлэнх нь харь үндэстэн байсаар ирсэн. Тэгэхээр бид ч бас алдаа гаргаагүй гэсэн үг юм. Христийн дагалдагчдын хувьд бид энэ нь жинхэнэ авралыг авчрах цор ганц үнэн мэдээ гэдгийг мэдэж, гэмшил ба итгэлийн Сайнмэдээг дэлхийн бүх хүнд тунхаглах үүрэг билээ.



## ХАМТРАГЧИД

---

**Др. Пит Алвинсон (Хөтлөгч)** нь FORGE буюу “Толин тусгал дахь Эрэгтэй” гэх хот даяарх эрчүүдийн үйлчлэлийн гүйцэтгэх захирал. Тэрээр мөн Флорида мужийн Винтер Спрингс дэх Виллоу Грик Пресбитериан чуулганы (РСА) үүсгэн байгуулагч бөгөөд 26 жилийн турш Тэргүүн Пастороор үйлчилсэн нэгэн юм. Доктор Алвинсон нь Библи Судлалын магистрын зэргээ Тринити Евангелийн Дивинити сургуульд, Үйлчлэлийн Докторын зэргээ Шинэчлэлийн Теологийн Сургуульд тус тус хамгаалсан. Тэрээр Шинэчлэлийн Теологийн Сургуулийн дэд профессор, Амьдралын Түлхүүр Сүлжээний Удирдах Зөвлөлийн Гишүүн. Тэрээр *Аав шиг, Хүү шиг: Бурханыг аав шигээ мэдэх нь хүмүүсийг хэрхэн өөрчилдөг вэ?* номын зохиогч юм.

---

**Др. Ричард Баукхэм** нь Шинэ Гэрээний эрдэмтэн, зохиолч бөгөөд Шотландын Гэгээн Андрей их сургуулийн хүндэт профессор.

**Др. Дэвид Р. Бауэр** нь Асбери Теологийн Сургуулийн Индактив Библи Судлалын Ральф Валдо Бисон Профессор бөгөөд Библийн Тайллын Сургуулийн хичээлийн эрхлэгч.

**Др. Питер Чоу** Тайвань дахь Хятадын Евангелийн Сургуулийн Ерөнхийлөгч асан (тэтгэвэрт гарсан), одоо Их Филадельфийн Тринити Христийн Чуулганд хагас цагаар пасторын үйлчлэл хийдэг.

**Рев. Майкл Ж. Глодо** бол Флоридагийн Орландо дахь Шинэчлэлийн Теологийн Сургуулийн Пасторын Теологийн дэд профессор юм.

**Др. Стив Харпер** нь Флорида мужийн Орландо дахь Асбери Теологийн Сургуулийн Флорида-Дуннам кампусыг үүсгэн байгуулагч дэд ерөнхийлөгч бөгөөд Сүнслэг Байгуулалт, Вэсли Судлалын тэтгэвэрт гарсан профессор.

**Др. Грегори Р. Пэрри** нь Гурав дахь Мянгын Үйлчлэлийн Стратегийн Төсөл хариуцсан дэд ерөнхийлөгч, Гурав дахь Мянгын Семинарийн Ерөнхийлөгч. Тэрээр өмнө нь Ковенант Теологийн Сургуульд Шинэ Гэрээний дэд профессор, Хотын Үйлчлэлийн Санаачилгын захирлаар ажиллаж байсан.

**Др. Дэвид А. Ределингс** нь Бетел Сургуулийн Шинэ Гэрээний профессор

**Др. Марк Л. Страусс** бол Сан Диего дахь Бетел Сургуулийн Шинэ Гэрээний профессор.

**Др. Фрэнк Тиелман** бол Бисон Дивинити Сургуулийн Шинэ Гэрээний Дивинити Пресбитериан профессор.

**Др. К. Эрик Тоеннес** нь Биола Их Сургуулийн Талбот Теологийн Сургуулийн Библи ба Теологи Судлалын профессор, Библи ба Теологи Судлалын теологийн тэнхимийн эрхлэгч.

**Др. Петр Волкер** нь Тринити Сургуулийн Библи судлалын профессор, Оксфордын Уиклиф Холлд дэд захирал асан. Одоо Библи судлалын Иерусалим Төвд багш

**Др. Стивен Ж. Вэллум** бол Өмнөдийн Баптист Теологийн Сургуулийн Христэч Теологийн профессор юм.

**Др. Бен III Витерингтон** нь Асбери Теологийн Сургуулийн Докторын судалгааны Шинэ Гэрээний Амос номын профессор

## ҮГСИЙН ТАЙЛБАР

**Абрахам** – Хуучин Гэрээний өвөг, Терагийн хүү, Израил үндэстний эцэг. Бурхан Эхлэл 15, 17-р бүлэгт түүнтэй гэрээ байгуулж, тоо томшгүй олон үр удам, онцгой газар нутгийг Түүнд амласан.

**Марсионы эсрэг оршил үгс** - Сайнмэдээний номуудын эртний оршил үгс (ойр. МЭ 160-180). Энд бичээч ба тэдний намтрыг дэлгэрэнгүй өгүүлдэг

**Александрын Клемент** - (ойр. МЭ 150-215) Анхны чуулганы эцэг, Александрын бичээч

**гэрээ** – Хоёр хүн эсвэл бүлэг хүмүүсийн хооронд, мөн Бурхан аливаа хүн ба бүлэг хүмүүстэй байгуулсан заавал биелүүлэх үүрэг бүхий хууль ёсны хэлцэл

**загалмайн цовдлол** – эртний Ромын эзэнт гүрний үед гэмт хэрэгтнүүдийг загалмайд уяж эсвэл хадаад, амьсгал хурааж үхэх хүртэл нь өлгөөтэй байлгадаг цаазаар авах ялын нэг хэлбэр. Есүс ийнхүү цовдлогдон нас барсан.

**Давид** - Хуучин Гэрээн дэх Израилын хоёр дахь хаан. Түүний үр удам хаан ширээнд сууж, мөнхөд хаанчлах болно гэсэн амлалтыг хүлээн авсан.

**Дэй (dei)**- "зайлшгүй шаардлагатай" гэсэн утгатай грек үг (галиг)

**Деспота (despota)**- "эзэн" эсвэл "мастер" гэсэн утгатай грек үг (галиг); "дээд эрх мэдэлтэй хүн"

**Габриел** – Даниел ном дахь Даниелийн үзэгдэлд ухаарал, ойлголтыг өгсөн, Лукийн Сайнмэдээнд Баптисч Иохан болон Есүсийн мэндэлснийг зарласан тэнгэрэлч.

**Харь үндэстэн** - Иудей биш хүн

**Иренаус** - (ойр. МЭ 130-202 он) 2-р зууны бишоп, эртний Христитгэгч зохиолч, *Тэрсүүдийн Эсрэг* номын бичээч, Гностик үзлийг няцааж, Сайнмэдээний дөрвөн номын үнэн зөвийг баталсан нэгэн

**Исаиа**—МЭӨ 740-701 онд Уззиа, Иотам, Ахаз, Хезекиа нарын хаанчлалын үед үйлчилж байсан Иудагийн эш үзүүлэгч.

**Иохан** – Зебедеен хүү, Иаковын дүү, арван хоёр элчийн нэг, Иоханы Сайнмэдээний Ном болон 1, 2, 3 Иохан, Илчлэл номын бичээч. Түүнийг "Есүсийн хайртай шавь" гэж нэрлэгдэг.

**Баптисч Иохан** – Жинхэнэ гэмшлийг уриалж, Бурханы хаанчлал ирэхэд ойрхон байгааг тунхагласан Шинэ Гэрээний эш үзүүлэгч. Есүсийг Мессиа гэж тодорхойлж, Түүний олон нийтэд үйлчлэх замыг бэлтгэсэн нэгэн

**Бурханы хаанчлал** – бүх бүтээлийн дээгүүрх бүрэн эрхт, үл өөрчлөгдөх захиргаа

**кратисте/кратистос (kratiste/kratistos)**— "эрхэм хүндэт" гэсэн утгатай грек үг (галиг). Энэ нь эрхэм дээд нэр хүндтэй хүнийг хэлдэг ба заримдаа Ромын захирагчдыг ингэж нэрлэдэг. Лук Сайнмэдээндээ болон Үйлс номдоо Теофилийг ийнхүү тодотгосон байдаг.

**Леви** – Урьд татвар хураагч байсан элч Матайн өөр нэг нэр. Мөн тахилчаар үйлчилж байсан Израилын овог

**Лук** – Гурав дахь Сайнмэдээний ном болон Үйлс номын бичээч, Христитгэгч харь үндэстэн бөгөөд Паулын хамтран зүтгэгчдийн нэг. Түүнийг эмч байсан гэж үздэг

**Магнификат** –Мариа өөрийнх нь хүүхэд болох Есүсээр дамжин ирэх авралд үлэмж ихээр баярлан Бурханд өргөсөн магтуу

**Марк** – Иохан Марк гэгддэг; Маркийн Сайнмэдээний номын бичээч, Барнабын үеэл, Паул ба Барнаб хоёрын илгээлтийн анхны аялалд дагалдан явсан нэгэн

**Матай** – Есүсийн арван хоёр дагалдагчдын нэг, Матайн Сайнмэдээний номын бичээч. Есүс түүнийг дуудах үед тэрээр татвар хураагч байсан ба түүнийг мөн Леви гэдэг

**Мессиа** – "тослогдсон нэгэн" гэсэн утгатай еврей үг. Энэ үеэс ирэх үе рүү шилжих шилжилтийг авчрах Давидын удмын агуу хаан. Грек хэлэнд "*Христос*" гэж орчуулдаг.

**Моце** – Израилчуудыг Египетээс гаргасан чөлөөлөгч, Хуучин Гэрээний эш үзүүлэгч. Бурхантай үндэстний "хуулийн гэрээ" байгуулж, Израилчуудад Арван Тушаал болон Гэрээний Номыг сахиулсан нэгэн. Мөн Есүсийг хувирч өөрчлөгдөх үед Елиатай хамт байсан нэгэн

**Мураторын бичвэр**- Чуулган канонд оруулсан Шинэ Гэрээний номуудыг жагсаасан хамгийн эртний баримт бичиг (МЭ 170-180 он)

**Неро** – МЭ 54-68 онд Ромыг захирч байсан эзэн хаан, Христитгэгчдийг хавчигч нэгэн. Тэрээр МЭ 64 онд Ромд гарсан түймэрт Христитгэгчдийг буруутгасан бөгөөд Паулыг цаазалсан (уламжлалын дагуу)

**палеограф** - Түүхэн бичвэрийн он цагийг тайлдаг эртний гар бичвэр судлал

**Панирус 75** - Лук ба Иохан номын хэсгээс агуулсан МЭ 175- МЭ 200 оны хооронд хуулбарлагдсан, эртний бичвэр

**сургаалт зүйрлэл** – сүнслэг болон ёс суртахууны хичээл заахад ашигладаг богино ёгт түүх

**Алгасал баяр**- Бурхан Израилчуудыг Египетийн боолчлолоос чөлөөлсөн үеийг дурсан тэмдэглэдэг Идейн баяр

**Петр** – Симон гэгддэг Есүсийн арван хоёр дагалдагчдын нэг, анхны Христийн чуулганы удирдагч, Үйлс 2-р бүлэгт Пентекостын өдөр номлосон нэгэн. Чуулганы түүхчдийн үзэж байгаагаар Марк Сайнмэдээгээ бичихдээ Христийн амьдралын талаар бичсэн Петрийн түүхэнд тулгуурласан гэдэг.

**Фарисайчууд** – Хуулийг чанд мөрддөг гэдгээрээ алдартай 1-р зууны үеийн Иудейн шашны бүлэг. Тэд Ирээдүйн амилалд итгэдэг байсан ч мөн Израил Хуульд дуулгавартай байх хүртэл Бурхан хөндлөнгөөс оролцохгүй гэдэгт итгэдэг

**эш үзүүлэгч** – Бурханы үгийг тунхаглаж, хэрэгжүүлдэг, ялангуяа гэм эсрэг шүүлтийг сэрэмжлүүлж, ерөөлд хөтлөх үнэнч үйлчлэлийг урамшуулдаг Бурханы төлөөлөгч

**Самаричууд** – Харийн шашинтай өвөг дээдэс нь хойд хаанчлалын Израилчуудтай гэрлэсэн Самарын хүмүүс. Тэд Иудейн шашныг өөр шашинтай хольж хутган дагадаг байсан ба Иудейчүүд тэднийг бузар хэмээн жигшдэг байв.

**Симеон** –Ариун Сүнс өөрт нь Мессиаг харах хүртлээ үхэхгүй гэж баталсан Шинэ Гэрээнд гардаг зөвт, үнэнч хүн. Лук 2-р бүлэгт тэрээр нялх Есүсийг Мессиа гэж тунхагласан байдаг

**Давидын Хүү** – Мессиаг хэлдэг нэр. Тэрээр Давидын удмаас гарч, Бурханы ард түмнийг аврах удаан хүлээлгэсэн, зөвт

Нэгэн. Шинэ Гэрээнд Есүсийг ийнхүү хэлдэг байсан (ялангуяа Матай номд)

**Хүний Хүү** – Хуучин Гэрээний эш үзүүлэгч дэх Мессиагийн нэр. Шинэ Гэрээнд Есүсийг тодорхойлохдоо ашигласан байдаг

**синоптик** - "хамтад нь харах" гэсэн утгатай нэр томьёо. Матай, Марк, Лук нарын Сайнмэдээний номуудын ижил төстэй байдлыг тодорхойлоход ашигладаг үг

**Тертуллиан** - (ойр. МЭ 155-230)- Эртний Христитгэгч зохиолч, чуулганы эцэг, *"Марсионы Эсрэг"* зохиол бичиж,

Гурвалын талаарх Латин нэр томьёог дэлгэрүүлсэн нэгэн.

**Теофил** – Лук өөрийн Сайнмэдээ болон Үйлс номыг аль алиныг нь зориулан бичсэн хүн

**Хувиран өөрчлөгдөлт** – Есүс дагалдагч нартаа Өөрийн алдраа илчилсэн талаар Матай 17:1-8, Марк 9:2-8, Лук 9:28-36-р эшлэлүүдэд тэмдэглэгдсэн үйл явдал

**Закхай** – Иерихогийн ахлах татвар хураагч, биеэр нам түүнийг Есүс дуудсаны дараа баялгийнхаа талыг ядууст өгч, завшсан мөнгөө дөрөв дахин эргүүлэн өгөхөө амласан нэгэн.